

Шударга сонгуулийн төлөө
иргэний нийгмийн хяналт сүлжээ

СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААХ, ТООЛОХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН

Улсын Их Хурал, Нийслэлийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын сонгууль – 2016

Улаанбаатар хот

2016 он

СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААХ, ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН

**улсын их хурал, нийслэлийн иргэдийн
төлөөлөгчдийн хурлын сонгууль – 2016**

Энэхүү төслийг Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын
санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэв.

Төслийн тайланг боловсруулсан:

Б.Золзаяа, Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ-ын Захирал
Ц.Мандхайхатан, “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын Захирал
А.Санчирмаа, Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ-ын Залуучуудын хөгжлийн
хөтөлбөрийн менежер

Хянасан:

Д.Энхцэцэг, Шударга сонгуулийн төлөөх иргэний нийгмийн хяналт сүлжээний Зохицуулагч,
Нээлттэй Нийгэм Форумын менежер

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт

Өмнөх үг

Товч агуулга

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- 1.1 Төслийн зорилго ба зорилтууд
- 1.2 Төслийн зохион байгуулалт
- 1.3 Төслийн үйл ажиллагаа

ХОЁР. АЖИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ

- 2.1 Ажиглалтын аргачлал

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- 3.1 Сонгуулийн үйл явцыг төрийн бус байгууллагаас ажиглагч ажиглах эрх зүйн зохицуулалт
- 3.2 Төрийн бус байгууллагын ажиглагчийн эрх, үүрэг
- 3.3 Сонгуулийн санал авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт
- 3.4 Сонгуулийн санал тоолох, дүн гаргах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

ДӨРӨВ. АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1 Дотоодын байгууллагын ажиглагчийг бэлтгэх үйл ажиллагаа
- 4.2 Дотоодын байгууллагын ажиглагчаар бүртгүүлэх үйл явц

ТАВ. АЖИГЛАЛТЫН ДҮН

- 5.1 А – Санал авах ажиллагааны нээлт
 - Орчин
 - Автоматжуулсан системийн бэлэн байдал
 - Санал авах ажиллагааг эхлүүлэх
- 5.2 Б – Санал авах ажиллагаа
 - Санал авах ажиллагаа

- Санал авах ажиллагааны зөрчил
- Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл

5.3 В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах

- Санал авах ажиллагааг хаалт
- Санал тоолох үйл ажиллагааны бэлтгэл
- Санал тоолох ажиллагаа
- Санал хураалтын дүн гаргах
- Санал тоолох ажиллагааны зөрчил
- Санал тоолох үе дэх төхөөрөмжийн саатал, гэмтэл
- Техникийн тооллого

5.4 Ажиглалт хийх үед тулгарсан хүндрэл, бэрхшээл

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ:

1. Иргэний нийгмийн ажиглагчийн баримтлах ёс зүйн дүрэм
2. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас бөглөх заавар, зөвлөмж
3. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: А – Санал авах ажиллагааны нээлт
4. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: Б – Санал авах ажиллагаа
5. Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас: Санал авах ажиллагааны Б шалгах хуудас
6. Иргэний нийгмийн ажиглагчийн шалгах хуудас: В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах
7. УИХ, НИТХ-ын Сонгуулийн үйл явцын ерөнхий үнэлгээ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ- Улсын Их Хурал

НИТХ-Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал

СтХ- Сонгуулийн тухай хууль

СЕХ- Сонгуулийн Ерөнхий Хороо

ТББ-Төрийн бус Байгууллага

ХБИ- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

ТББ- Төрийн бус байгууллага

ННФ- Нээлттэй Нийгэм Форум

ӨТЗЭ- Өөрчлөлтийн төлөөх Залуу Эмэгтэйчүүд

БЗХ-Бодлогод залуусын хяналт

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үнэт зүйл болох хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлооход нэн тэргүүний шалгуур бол засгийн эрх мэдэл ард түмний хүсэл эрмэлзлээр баталгаажиж буй эсэх билээ. Үүний нэг илрэл, хэрэгжих арга зам нь бүх нийтийн, чөлөөт, шууд, ил тод, шударга сонгууль юм. Үүгээр зогсохгүй сонгууль нь тухайн улс оронд хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа иргэний улс төрийн эрх ямар түвшинд хангагдаж буйн илэрхийлэл, нийгмийн чухал институцууд үүргээ зохих ёсоор гүйцэтгэж буй эсэхийн шалгуур болдог билээ.

Сонгууль ил тод, шударга явагдах нөхцлийг хангах үүднээс, нарийвчилбал хууль, журамд заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд иргэний нийгмийн байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих нь сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, болзошгүй зөрчил бүдлианаас сэргийлэх, улмаар сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Ийнхүү 2012 оны Улсын Их Хурлын сонгуулиас эхлэн төрийн бус байгууллагууд сонгуульд мониторинг хийх, хөндлөнгийн хяналт тавих эрхийг хуульд тусган баталгаажуулсан болно. Хуулийн хүрээнд бий болсон боломжид үндэслэн Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт сүлжээний зүгээс 2016 оны УИХ, НИТХ-ын сонгуулийн үйл явцад санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцад хөндлөнгөөс хараат бус ажиглалт, хяналт хийсэн.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагууд нь 2016 оны УИХ, НИТХ-ын сонгуулийн үйл явцад (1) Хэвлэл мэдээллийн мониторинг, (2) сонгуулийн автоматжуулсан системийн мониторинг, (3) сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг, (4) санал хураах, дүнг гаргах үйл явын ажиглалт гэсэн дөрвөн чиглэлээр мониторинг хийж гүйцэтгэв.

2016 оны УИХ-ын сонгуулийн хувьд өмнөх сонгуулиас ялгагдах онцлог гэвэл сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулж эргэн мажоритар тогтолцоонд шилжсэн явдал билээ. Түүнчлэн өмнөх сонгуулиар эхлүүлсэн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зэрэг зохион байгуулах болон сонгуулийн санал тоолох үйл ажиллагааны автоматжуулалтын системийг үргэлжлүүлэн хэрэглэсэн.

ТОВЧ АГУУЛГА

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 14-р бүлэгт заасныг үндэслэн иргэний нийгмийн залуучуудын байгууллагууд хамтран хөндлөнгийн, бие даасан ажиглалт хийснээр сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, сонгуулийг шударга, зөрчил бүдлиангүй болгох, олон нийт, ялангуяа залуучуудын сонгуульд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулсан чухал ач холбогдолтой төсөл хэрэгжсэн гэж үзэж байна.

Энэхүү ажиглалтыг удирдан зохион байгуулах ажлыг тус Сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөө Залуу эмэгтэйчүүд ТББ болон Бодлогод залуусын хяналт ТББ хамтран гүйцэтгэсэн ба ажиглалтын аргачлалыг 2004, 2008, 2009 болон 2012 оны сонгуульд ажиглалт хийсэн иргэний нийгмийн түршлага болон Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Бүсийн сүлжээ мөн Филиппиний Чөлөөт Сонгуулийн Иргэдийн Үндэсний хөдөлгөөний ажиглалт хийх аргачлалд үндэслэн боловсруулсан юм.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний 202 сайн дурын ажиглагч 2016 оны 6-р сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын (УИХ) сонгуулийн үйл явцад ажиглалт хийлээ. Уг ажиглалтад Улаанбаатар хотын сонгуулийн 9 дүүргийн 101 хэсгийн хороо буюу нийт хэсгийн хорооны 25 хувь нь хамрагдсан бөгөөд сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдаж буй эсэхэд ажиглалт, хяналт тавьлаа. Түүнчлэн ажиглалт хийсэн нийт 101 хэсгийн хороодоос 23 хэсгийн хороод сугалааны зарчмаар сонгогдож техникийн тооллогод хамрагдсан болно.

Ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас хэсгийн хороод санал хураалтад бэлтгэснээс эхлэн санал хураах, санал тоолох үйл ажиллагаа, техникийн тооллого болон сонгуулийн эцсийн дүнг хэсгийн хороод хуралдаанаараа батлах үйл явцыг хамарсан. Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажиллагааг хянаагүй болно. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг шалгах хуудас, санал тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан болно.

Төрийн бус байгууллагын 202 ажиглагчийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзвэл 2016 оны Монгол Улсын Их Хурал, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц хуулийн хүрээнд явагдсан ба сонгуулийн дүнд

нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсгийн хороод дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Санал авах байр, орчин:

Санал авах байрны орчин, дотоод зохион байгуулалт, аюулгүй байдал, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд үзүүлэх дэлгэцийг бэлдсэн зэрэг хэсгийн хороодын зохион байгуулалт сайн байсан ч дараах дутагдлууд ажиглагдсан. Үүнд:

- Хэд хэдэн хэсгийн хороо санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас үүдэлтэй сонгогч саналаа нууцаар бэлтгэх боломж бага, саналын нууцлал алдагдах магадлалтай байсан.
- Тэргэнцэртэй иргэдийг зорчих налуу замыг хэсгийн хороодын 72 хувь нь урьдчилан бэлтгээгүй.
- ТББ-ын ажиглагчдыг санал авах үйл явцыг саадгүй ажиглах боломжтой орчинг хэсгийн хороодын 20 хувь нь бүрдүүлээгүй байсан.

Санал хураах үйл явц:

Ажиглалт явагдсан хэсгийн хороодын санал хураах үйл явцыг ерөнхийд нь дүгнэхэд хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан. Хэсгийн хороод хуульд заасан цагт санал авах ажиллагааг эхлүүлсэн бөгөөд зарим газарт санал авах төхөөрөмжийг угсрах, ажиллуулах зэрэгт их цаг зарцуулсны улмаас бага зэрэг хожимдож эхлүүлсэн тохиолдол гарсан.

Сонгуульд санал өгөхтэй холбоотой мэдээлэл сонгогчдод дутмаг байснаас үүдсэн зарим хүндрэл ажиглагджээ. Үүнд: Сонгогч саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх талаарх мэдээлэл дутмагаас болж 2000 гаруй саналын хуудас хүчингүй болсон, санал хураах төхөөрөмжид саналын хуудсаа хэрхэн уншуулах талаар мэдээлэл дутмагаас үүдэж хэсгийн хороодын 51 хувьд нь саналын хуудсыг төхөөрөмжид уншуулахад хүндрэл гарч байсан байна. Үүний улмаас сонгогчийн саналын нууцлал алдагдах эрсдэл гарсан байна. Мөн сонгогчид санал өгөх хэсгийн хороогоо андуурсан тохиолдлууд цөөнгүй гарсан байна.

Санал тоолох төхөөрөмж болон хурууны хээ таних төхөөрөмжийн ажиллагаа:

Ажиглагчдаас ирүүлсэн мэдээллээс үзвэл хурууны хээ таних төхөөрөмжийн ажиллагаатй холбоотой хүндрэлүүд тэмдэглэгдээгүй байна. Хэсгийн хороодын 91 хувь нь сонгогч тус бүрийн хурууны хээг уншуулан таниулж, иргэний үнэмлэхний мэдээлэлтэй тулгаж нягталж байсан гэсэн бөгөөд зарим хэсгийн хороод хурууны хээ уншиж буй тохиолдолд, иргэний

үнэмлэх шаардаагүй байна. Мөн долоовор хурууны хээ таниагүй тохиолдолд хэсгийн хороодын 90 хувь нь бусад хуруунуудыг уншуулж байсан байна.

Санал тоолох төхөөрөмжинд 59 хувьд нь саатал, эвдрэл, гэмтэл гараагүй гэсэн бөгөөд саатал, гацалт, гэмтэл гарсан тохиолдлуудад мэдээллийн даамал тухай бүр нь засварлаж, шаардлагатай тохиолдолд буюу ажиглалтанд хамрагдсан 3 хэсгийн хороонд Сонгуулийн ерөнхий хорооны засварлах баг ирж тухай бүр нь асуудлыг шийдвэрлэжээ.

Санал тоолох үйл явц:

Санал тоолох үйл явцыг төрийн бус байгууллагын 101 ажиглагч хэсгийн хороодод биечлэн ажигласан бөгөөд ажиглагчдын 86 хувьд санал тоолох үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаж болохуйц байсан. Ажиглагчдын мэдээллээс үзвэл санал тоолох үйл явцад ноцтой зөрчил, дутагдал гараагүй бөгөөд нээлттэй, ил тод явагдсан байна.

Хэсгийн хороодын 83 хувьд нь санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж эвдэрч, гацаагүй, 79 хувьд санал тоолох ажиллагаа завсарлалгүй, шууд явагдсан гэсэн бөгөөд зарим хороодод санал тоолж хэвлэх үед цаас нь дууссан, тоолж эхлэх гэсэн зааварчилгаа хүлээсэн, СЕХ-оос техникийн тооллого явагдах эсэхийг хүлээсэн, намын төлөөлөл нэмж орж ирсэн зэрэг шалтгаантай байсан байна.

Ийнхүү нийт хэсгийн хороодын 92 хувь нь саналын хуудасны дүнг ажиглагчдад хэвлэж өгсөн ба 73 хувь нь дүнг уншиж сонгон, 82 хувь нь нэн даруй мэдээлжээ. Мөн 82 хувь нь саналын хуудасны зурган файлыг ажиглагчдад CD дээр хуулж өгсөн боловч бусад хэсгийн хороод техникийн мэдлэг болон бэлтгэл хангалтгүй, зурган файлыг хуулж авах хүсэлтээ бичгээр гаргах, заавал DVD авчрахыг шаардсанаас зарим хэсгийн хороо ажиглагчид мэдээллийг авч чадсангүй.

Техникийн тооллого:

Төрийн бус байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл 8 дүүргийн техникийн тооллого явагдах хэсгийн хороодыг сугалаагаар шодох үйл ажиллагаанд хөндлөгийн ажиглалт хийж оролцсон. Ийнхүү бидний сонгосон 101 хэсгийн хорооноос 23 хэсгийн хороо сугалаагаар техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон.

Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц 100 хувь ажиглагчдад нээлттэй явагдсан ба СЕХ-оос баталсан журмын дагуу явагджээ. Техник тооллого дунджаар 1:30 минутын дараа эхэлсэн ба дунджаар 4-12 цаг үргэлжилсэн.

Мөн энэ хэсгийн хороод дээр 7 дээр нь саналын хуудас болон санал авах машины санал зөрөх тохиолдол гарсан байна. Тодруулбал 1-10 саналын зөрүү гарах тохиолдлууд байсан

ба шалтгаан нь нэр дэвшигчийн өмнөх дугуйг хэтрүүлэн тэмдэглэсэн байдал, мөн хэсгийн хороодын ажилчид олон цаг завсарлалгүй ажилласны улмаас алдаж тоолох тохиолдлууд ажиглагдсан байна.

Ажиглагт хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:

Ажиглагчдад мэдээлэх шаардлагатай зарим мэдээллийг дутуу хэлэх, орхих, санал тоолох төхөөрөмжийн гэрчилгээ, серийн дугаарыг тэмдэглэж, мэдээлэл авах, саналын хуудасны зурган файлыг хуулбарлан авах боломжоор бүх хэсгийн хороод хангаж чадаагүй. Ялангуяа хэсгийн хороодод ажиглагчдыг бүртгүүлэхэд хуульд заагаагүй бичиг баримт шаардах, 4-5 удаа дахин явуулах зэрэг хүндрэл учирч байсан.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн зорилго ба зорилтууд

ЗОРИЛГО

Төсөл нь дараах 2 зорилго тавин ажилласан болно. Үүнд:

1. 2016 оны УИХ, НИТХ-ын сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах үйл явц нь хууль болон тогтоосон журмын дагуу явагдаж буй эсэхийг зохих аргачлалын дагуу хянаж, хяналт тавих, уг үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, улмаар болзошгүй зөрчлөөс сэргийлэх
2. Иргэдийн сонгуулийн оролцоог дэмжих аяныг зохион байгуулж сонгуулийн насны иргэд, тэр дундаа залуусын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн идэвх оролцоог мэдээллийн орчин үеийн болон уламжлалт сүвгүүдыг ашиглан мэдээлэл түгээх аргаар нэмэгдүүлэх зорилготой.

ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсөл нь зорилгынхоо хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

1-р зорилгын хүрээнд

- Сонгуулийн санал авах, санал тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийж, хяналт тавих замаар уг үйл ажиллагаа хуульд заасан журам, нөхцлийн дагуу явагдаж буй эсэх, нээлттэй, ил тод байх хуулийн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох, зөрчлийг баримтжуулах;
- Сонгуулийн үйл явцад хяналт тавих иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, үүнд залуучуудыг татан оролцуулах замаар иргэний боловсролд нь хувь нэмэр болох ;
- Мөн ажиглалтын дүнд үндэслэн сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход нөлөөлөх явдал юм.

2-р зорилгын хүрээнд

- Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх, сонгуулийн идэвх, оролцоог дэмжих зорилго бүхий дотоодын болон олон улсын сайн туршлагад үндэслэсэн мэдээллийн багцыг бэлтгэн боловсруулах;

- Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх хүрээнд Сонгуулийн тухай хууль, түүний хүрээнд дагаж мөрдөх журмыг тайлбарлан, агуулга, хэлбэрийн хувьд хялбаршуулан мэдээллийн сүвгуудыг ашиглан түгээх;
- Иргэдийн сонгуулийн идэвх, оролцоог дэмжих хүрээнд ардчилсан нийгэм, түүний үнэт зүйлс, сонгуулийн ач холбогдлыг танин мэдүүлэх зорилго бүхий мэдээллийг хялбаршуулан сонирхолтой хэлбэрээр мэдээллийн сүвгуудыг ашиглан түгээх юм.

1.2 Төслийн зохион байгуулалт

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллага болох Өөрчлөлтийн төлөөх Залуу эмэгтэйчүүд ТББ-ын захирал Б.Золзаяа төслийн удирдагчаар, Бодлогод залуусын хяналт ТББ-ын захирал Ц.Мандхайхатан болон Өөрчлөлтийн төлөөх Залуу эмэгтэйчүүд ТББ-ын Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн менежер А.Санчирмаа нар төслийн дэд зохицуулагчдаар ажилласан.

Мөн сүлжээний гишүүн байгууллагуудын төлөөлөл болон бусад иргэний нийгмийн байгууллага, их сургуулийн оюутнууд зэргээс ажиглагчдын баг бүрдсэн. Үүнд:

- Өөрчлөлтийн төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ,
- Бодлогод залуусын хяналт ТББ,
- Өөрчлөлтийн салхи ТББ,
- AIESEC Mongolia-ТББ,
- Нийтлэлч залуусын клуб,
- МУИС-ийн Энтимема клуб
- Хөөрхөн зүрхнүүдийн аян
- Охидын эрхийг хамгаалах Гүнж төвийн ажлын алба
- Гүнж төвийн дэргэдэх залуу эхчүүдийн клуб,
- Шихихутаг ДС-ийн багш, оюутнууд
- Сайн дурын идэвхтэн, хувь хүмүүсээс бүрдсэн 202 ажиглагч, тэднийг удирдан зохион байгуулсан 25 хүний бүрэлдэхүүнтэй баг, нийт 227 хүн оролцон ажилласан байна.

1.3. Төслийн үйл ажиллагаа

Төслийн зорилго, зорилтод чиглэсэн дараах үйл ажиллагааг төслийн хүрээнд зохион байгуулав.

- Сүлжээний иргэний нийгмийн байгууллагуудын туршлагад үндэслэн ажиглалтын аргачлал боловсруулах;
- Ажиглагчдыг иргэний нийгмийн болон залуусын байгууллагуудаас тодорхой шалгууртайгаар сонгон авч, холбогдох хууль, журам болон ажиглагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалт зохион байгуулах;
- Ажиглагчдыг СЕХ-ноос баталсан зохих журмын дагуу бүртгүүлэх ажлыг нэгдсэн удирдлагатайгаар зохион байгуулах;
- Сонгуулийн санал хураах, санал тоолох, дүн гаргах үйл ажиллагааг ажиглах, санал тоолох үйл явцтай холбоотой мэдээлэл цуглуулах;
- Сонгуулийн ажиглалтын дүнг олон нийтэд хүргэж тайлагнах;
- Ажиглалтын үр дүн, санал зөвлөмж бүхий тайлан боловсруулан гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх,
- Олон нийтийн сонгуулийн идэвх оролцоог дэмжихэд чиглэсэн нийгмийн сүлжээн дэх мэдээ, мэдээлэл түгээх аяныг зохион байгуулах,
- Олон нийтийн сонгуулийн идэвх оролцоог дэмжихэд чиглэсэн олон нийт, тэр дундаа залуус руу чиглэсэн урлаг, агуулга хослосон арга хэмжээ зохион байгуулах

Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа:

2016 оны 6-р сарын 4-5-ны өдрүүд. Сонгуулийн ач холбогдлыг таниулж, сонгуулийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, мөн нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрахад иргэд өөрийн бүтээлч чадвараа ашиглах боломжийг нээх, мэдрүүлэх зорилготой Санал бүхэн үнэ цэнэтэй уриан дор **МИНИЙ ГАР** хэмээх артивизм буюу “арт+активизм” олон нийтийн оролцооны урлагийн арга хэмжээг чөлөөт уран бүтээлч Б.Мөнхцэцэгтэй хамтран Улсын Драммын Эрдмийн театрын урд талбайд зохион байгуулсан.

Артивизм гэдэг нь тулгамдаж буй нийгмийн асуудлаар үзэл бодлоо илэрхийлэхдээ өөрийн бүтээлч чадвараа ашиглан бусадтай урлагаар холбогдохыг ойлгоно. Уран бүтээлчид урлагаар дамжуулан хүмүүстэй холбогдох нь нийгмийн эерэг өөрчлөлтийн төлөөх нөлөөллийн сүүлийн үеийн Дэлхийн чиг хандлага болоод байна. Энэхүү аргын онцлог нь ойлголцлын өндөр төвшнийг хялбар бий болгодгоороо олон нийтийн дунд шууд ярихад уйтгартай, нуршуу эсвэл хүнд боловч маш чухал сэдвүүдийн талаар мэдээлэл өгч, анхаарлыг хандуулж, тэдгээрийг өөрчлөхөд уриалж чаддагт оршино.

“Санал бүр үнэ цэнэтэй” гэсэн утгыг илэрхийлсэн гарын дүрстэй 500 ширхэг баримлыг сонгосон талбай дээр байршуулан, иргэд уг баримлуудаас сонгон өөрийн хүссэн өнгө,

дүрслэл, мэдрэмжээрээ урлан будаж, ийнхүү эдгээрийг хамтад нь инсталляци болгон байрлуулсан. Хүмүүсийг биечлэн оролцуулж, тодорхой зорилготой, үзэл санаатай бүтээлийг түүрвиулах нь тэдгээр хүмүүсийн сонгууль бас саналын үнэ цэнэ, ач холбогдлыг эргэцүүлүүлэх зорилготой юм.

Үйл ажиллагаа эхэлснээс 4 цагийн дотор 500 гар бүтээлүүд бүрэн будагдаж, 6-р сарын 5-ны өдийг дуустал инсталляци байршиж, иргэдийн сонирхлын ихээр татсан төдийгүй хүрэлцэн ирсэн иргэн бүрт буюу 3,000-аад иргэнд сонгуулийн саналын ач холбогдлыг таниулсан мэдээллийг түгээсэн болно. Мөн гар будаж бүтээсэн иргэд, залуучууд өөрийн бүтээлээ дурсгал болгон хадгалж авсан. Энэхүү олон нийтийн арга хэмжээг анх удаа зохион байгуулснаар онцлогтой байсан ба Сонгуулийн хуулийн 5.5-д заасны дагуу сонгогчдод эрхээ эдлэхэд нь туслах мэдээллийн хуудсыг, “ТА ШИЙД, ТА СОНГО, ТА ХЯНА” гарын бугуйвтай хамт 1000 гаруй иргэдэд түгээсэн.

Миний гар үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2 промо видеог хийж түгээсэн. IC Creative Division-тэй хамтарсан арга хэмжээний үйл явцыг баримтжуулан 2.47 минутын видео бүтээл гарган түгээсэн. Мөн үйл ажиллагааг мэргэжлийн гэрэл зурагчин баримтжуулан 2 цомог бүхий зургийг Facebook хуудаснаа нийтлэсэн. Мөн үйл ажиллагааг сурвалжлахаар Mongol HD, Eagle TV болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд хүрэлцэн ирсэнээр үйл ажиллагааны мэдээлэл өргөн хүрээнд тархсан.

Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх онлайн аян:

2016 оны 5-р сараас 7-р сарын 1-ныг хүртэл Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт <https://www.facebook.com/songogch> болон зохион байгуулагч байгууллагуудын сошиал медиа хуудсыг идэвхжүүлэн ажиллуулсан.

5-р сард хуудаснаа “Би саналаа өгнө. Яагаад гэвэл...” фото аянг зохион байгуулж #сонгуульажиглагч2016 хаштагийг ашиглан түгээсэн болно. Тус аянд 50 гаруй залуучууд дуу хоолойгоо илэрхийлэн оролцсон болно.

6-р сард залуучуудын идэвхтэй, хөгжилтэй хошин маягаар, товч мэдээллээ түгээх мэмэнүүдийг ашиглан саналаа өгөхийн утга учир, ач холбогдлыг илэрхийлсэн 20 зураг боловсруулж цомог болгон нийтэлсэн.

Мөн сонгуулийн өдөр Иргэний нийгмийн хараат бус, сайн дурын ажилтнуудыг ажиглалт хийж буй үйл ажиллагаатай танилцуулах, олон нийтэд мэдээллэхээр 5.51 минутын видеог 230 гаруй, 3.40 минут богино хэмжээний видеог 400 гаруй хүн үзжээ.

Мөн сонгуулийн сүүлийн долоо хоногт сонгогчдын боловсрольд зориулан саналаа өгөхийн ач холбогдол бүхий статистик мэдээллийг 4 инфографик боловсруулж нийтэлсэн.

2016 оны 6-р сарын 29-ны өдөр сонгуульд оролцох чухал ач холбогдолыг илэрхийлсэн “6.29 Сонгуульд саналаа өгнө! (чухал ажил)” зургийг төслийн 50 гаруй оролцогчид нүүр зургаа болгон өөрчилж, бусдад саналаа өгөх, идэвхжүүлэх аян өрнүүлсэн.

Хэвлэлийн хурал:

2016 оны 7-р сарын 1-ний өдөр. Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд зохион байгуулсан хэвлэлийн бага хурлаар сонгуулийн иргэний нийгмийн ажиглалтын үр дүнг танилцуулж, 25 орчим хэвлэл мэдээллийн төлөөлөгчид цугларсан бөгөөд Фэйсбүүк хуудсаар дамжуулан лайв бичлэг хийж баримтжуулж, түгээсэн болно.

Мөн тус өдөр 202 ажиглагч, багийн ахлагч нартаа батламж гардуулж, дурсгалт зураг авахуулсан болно. Хэвлэлийн хуудсыг хавсаргасан болно.

ХОЁР. АЖИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ

2.1. Ажиглалтын аргачлал

Сонгуулийн үйл явцын ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас санал авах хэсгийн хороод санал авахад бэлтгэснээс эхлэн санал авах, санал тоолох үйл ажиллагаа болон санал хураалтын дүнг хэсгийн хороод хуралдан батлах үйл явцыг хамарсан. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг шалгах хуудас, санал тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан.

Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажлыг хамраагүй болно.

Ийнхүү сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглаж, дүн шинжилгээ хийн, санал дүгнэлтийг боловсруулахад дараах аргуудыг ашиглав.

- Ажиглалт
- Санал асуулга
- Ярилцлага
- Баримт бичигт дүн шинжилгээ хийх

Ажиглалт:

Ажиглалтын аргачлалыг Филиппиний Чөлөөт сонгуулийн төлөө иргэдийн үндэсний хөдөлгөөн (NAMFREL/НАМФРЕЛ), Азийн чөлөөт сонгуулийн төлөө бүсийн сүлжээний (ANFREL/АНФРЕЛ) болон Европын байгууллагуудын аргазүй, туршлагад үндэслэн боловсруулсан 2012 оны ажиглалтын хуудсыг 2016 оны сонгуулийн хуульд зохицуулан шинэчлэн боловсруулсан болно. Дотоодын холбогдох хууль тогтоомж, журмыг түшиглэн ажиглалт хийх шалгах хуудсыг дараах 4 бүлэг асуудлаар тус бүр нарийвчлан боловсруулсны дотор:

1. “А - Санал авах ажиллагааны нээлт,”
2. “Б – Санал авах ажиллагаа,”
3. “В – Санал тоолох, санал хураалтын дүн гаргах” болон

4. “Иргэний нийгмийн ажиглагчийн зөрчил, гомдлыг бүртгэх хуудас” тус тус багтсан. Эдгээр шалгах хуудас нэг талаас сонгуулийн санал хураалтын үйл явцыг ажиглах хөтөч, нөгөө талаас баримтжуулах арга хэрэгсэл болсон юм.

Асуулга:

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороод хяналт тавьсан улс төрийн нам, эвслийн ажиглагчид сонгуулийн санал авах ажиллагаа, санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, санал тоолох ажиллагааны явцыг хэрхэн үнэлж буйг асуулгын аргаар судалсан.

Ингэхдээ дараах шалгуурыг ашигласан болно:

- | | |
|--------------------|---|
| 1. Маш сайн | Ямар нэгэн зөрчил гараагүй |
| 2. Сайн | Сонгуулийн үйл явц, санал тооллогын үйл явцад сөрөг нөлөө үзүүлээгүй, тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан |
| 3. Дунд | Сонгуулийн үйл явцад дүнд ноцтой нөлөө үзүүлээгүй зөрчил гарсан |
| 4. Муу | Сонгуулийн үйл явц, санал тооллогын дүнд сөргөөр нөлөөлсөн зөрчил гарсан |
| 5. Маш муу | Сонгуулийн үйл явц, санал тооллогын дүнг зөвшөөрөх боломжгүй болгосон зөрчил гарсан. |

Ярилцлага:

Хэсгийн хороод дээр манай ажиглагчид 6-16 цагийн хооронд, 16 цагаас сонгуулийн дүн гаргах хүртэл хугацаанд ээлжлэн хяналт тавьсан бөгөөд сонгуулийн үйл явцыг талаарх мэдээллийг шүүрхай хүлээн авч, баримтжуулах зорилгоор 6-16 цагын хооронд ажилласан нэгдүгээр ээлжийн ажиглагчидтай утсаар болон биечлэн ярилцаж дараахь асуудлуудаар мэдээлэл авсан.

Үүнд “Санал хураах үйл явц цагтаа эхэлсэн үү. Зохих дарааллын дагуу явагдсан уу,” “Сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой зөрчил гарч байна уу?” “Санал тоолох төхөөрөмжинд саатал, гэмтэл гарч байна уу?” “Санал авах ажиллагааны явцад сонгогч болон ажиглагч нараас гомдол гарч байна уу?” “Ажиглагт хийхэд ямар нэг хүндрэл бэрхшээл учирч байна уу. Тийм бол ямар?”

Мөн сонгуулийн өдрийн дараа тухайн хэсгийн хороонд ноцтой зөрчил гарсан болон тодруулах шаардлага гарсан ажиглагчидтай биечлэн уулзаж холбогдох мэдээллийг цаг алдалгүй баримтжуулсан болно.

Баримт бичигт дүн шинжилгээ хийх:

Сонгуулийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, мөн сонгуулийн хороодоос дотоодын байгууллагын ажиглалт болон санал авах, санал тоолох үйл явцтай холбогдуулан гаргасан шийдвэр эрх зүйн баримт бичгүүд, хэсгийн хороодын тогтоол, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн “эхлэлийн лог” хуудас, дүнгийн тайлан болон улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн бөглөсөн сонгуулийн ерөнхий үнэлгээ зэрэг баримт бичгийг нэгтгэн судалсан.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлын 2016 оны сонгуулийн ажиглалт нь Сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиуд, СЕХ-оос баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам,” “Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн сангийн мэдээлэл, түүнтэй холбогдох бусад мэдээллийг нууцлах, нууцалсан мэдээлэлтэй харьцах журам,” “Техникийн тооллого хийх тухай журам” зэрэг хууль тогтоомжийн хүрээнд явагдсан.

3.1 Сонгуулийн үйл явцыг төрийн бус байгууллагаас ажиглагч ажиглах эрх зүйн зохицуулалт

Сонгуулийн үйл явцад иргэд хяналт тавих боломжтой байх нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх гэсэн болзошгүй зөрчил будлианаас сэргийлж, сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй болох нь олон улсын туршлагаар нотлогдсон. Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт ТББ болон улс төрийн намаас ажиглагчийг томилон, сонгуулийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үйл явц, ажиглагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг анх удаагаа хуульд тусгасан онцлогтой байсан..

2015 оны Сонгуулийн тухай хуулийн 5-р зүйлд “Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим”-ын 5.5-д заахдаа:

“Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий **төрийн бус байгууллага** сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, **ажиглалт хийх**, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах **эрхтэй**” гэсэн.

Төрийн бус байгууллага сонгуулийн хууль тогтоомж хэрхэн биелж байгаад ажиглалт хийх, хяналт тавих эрхтэй болохыг сонгуулийн бусад зарчмуудын түвшинд тусгаж, хуулийн бусад заалтаар нарийвчилж тусгасан нь үндсэн зарчмууд хэрэгжихэд нөлөөлөхүйц дэвшил болсон.

Сонгуулийн тухай хуулиас...

5 дугаар зүйл: Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим

- 5.1.1. хууль дээдлэх;
- 5.1.2. ил тод байдлыг хангах;
- 5.1.3. шударга ёсыг сахих;
- 5.1.4. сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд нэгдсэн журмаар эхлэх, дуусах;
- 5.1.5. маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шийдвэрлэх;
- 5.1.6. сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх;
- 5.1.7. энгийн ойлгомжтой байх.

СтХ-ийн 5.5-ын “сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу” гэсэн заалтыг үндэслэн СЕХ-оос “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам”-ыг 2016 оны 3-р сарын 23-нд баталсан. Энэхүү журмын 1.4-т “Төрийн бус байгууллага нь энэ журамд заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлж дараах төрлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй” гэж урьдчилан бүртгүүлэх шаардлагыг тавьсан. Ийнхүү тус журмын 1.4.1-т “Сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх” гэж ТББ-ын үйл ажиллагааны төрлийг тодорхойлсон байна.

“Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам”-аас

Хоёр. Төрийн бус байгууллагыг бүртгэх

- 2.1 Төрийн бус байгууллага нь энэ журмын 1.1-д заасан үйл ажиллагаа явуулах тухай хүсэлтээ ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш сонгуулийн ерөнхий хороонд бичгээр ирүүлнэ.
- 2.2 Төрийн бус байгууллага нь энэ журмын 2.1-д заасан хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсаргана.
 - 2.2.1 байгууллагын дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 2.2.2 энэ журмын 1.4-т заасны дагуу явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө;
 - 2.2.3 байгууллагын санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл.
- 2.3 Энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор хянан үзэж шаардлага хангасан төрийн бус байгууллагатай гэрээ байгуулна. ингэхдээ дараах

байдлыг харгалзана. Үүнд:

2.3.1 аливаа улс төрийн намын харьяаллын бус, /нэр дэвшигч/

2.3.2 улс төрийн нам, эвслээс санхүүждэггүй байх.

2.4 Сонгуулийн Ерөнхий Хороотой гэрээ байгуулсан төрийн бус байгууллагыг үйл ажиллагаа явуулахад нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагууд дараах боломжоор хангана:

2.4.1 үндсэн ба зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах,

2.4.2 санал хураах, тоолох, төхөөрөмж болон түүний програмыг туршин шалгах ажиллагааг ажиглах...

Ийнхүү СЕХ-оос баталсан журмын дагуу бүртгүүлсэн ТББ-уудад сонгуулийн үйл явцыг ажиглах ажиглагчийг томилон ажиллуулах боломжтой болох бөгөөд ажиглагчид тавигдах шаардлага Сонгуулийн тухай хуулийн 107-р зүйлд тодорхойлсон.

Сонгуулийн тухай хуулиас...

107 дугаар зүйл: **Сонгуулийг ажиглах**

107.2.Бие даан нэр дэвшигч болон төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий **төрийн бус байгууллага нь нэг хэсэгт нэг ажиглагч томилон ажиллуулах эрхтэй.**

107.3.Ажиглагч нь арван найман нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.

107.4.Нэр дэвшигч, төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч ажиглагч байхыг хориглоно.

107.5.Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, үхуулагч нь ажиглагчаар томилогдсон бол сонгуулийн байгууллагын ажиллах болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Сонгуулийн тухай хуулийн 107.2-т ТББ нь хэсгийн хороонд нэг ажиглагчийг томилон ажиллуулахаар зохицуулсан бөгөөд 108.3-т зааснаар “Ажиглагчийн эрх нь ажиглагчийн үнэмлэх авснаар эхэлж, сонгуулийн албан ёсны дүн гарснаар дуусгавар болно” гэсэн.

Сонгуулийн тухай хуулиас...

107 дугаар зүйл: Сонгуулийг ажиглах

107.8 Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ бичгээр гаргаж, доор дурдсан баримт бичгийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлнэ:

107.8.1 ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар;

107.8.2 сонгуулийн төв байгууллагаас баталсан загварын дагуу бөглөсөн ажиглагчийн анкет;

107.8.3 ажиглагчаар томилогдсон этгээдийн нэг хувь цээж зураг.

107.9 Ажиглагчийг бүртгэх хугацаа өнгөрсөн бол санал авах байр ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахгүй буцаана.

107.10 Санал авах байр ажиглагчаар томилогдсон этгээд шаардлага хангасан эсэхийг шалгаж, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 48 цагийн дотор нягтлан шалгаж, шаардлага хангасан этгээдийг бүртгэж, ажиглагчийн үнэмлэх олгоно.

107.11 Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж санал авах байрын ажилд хөндлөнгөөс оролцвол санал авах байрын ахлах зохион байгуулагч ажиглагчийн бүртгэлийг хүчингүй болгон, үнэмлэхийг нь хураан авч, санал авах байраас гаргана.

107.12 Ажиглагч бүртгэлээс хасагдсан бол түүнийг томилсон этгээд нь орны хүнийг томилох эрхгүй бөгөөд ийм хүсэлт гаргавал санал авых байр хүлээн авахаас татгалзана.

107.13 Санал авах байрын багтаамжаас хамаарч ажиглагч томилох эрх бүхий этгээдийн томилсон бүх ажиглагч санал авах өдөр санал авах байранд ажиглалт хийх боломжгүй бол санал авах байр хоёроос доошгүй ажиглагчийг санал авах байранд ээлжлэн ажиглалт хийх боломжоор хангах үүрэгтэй.

107.14 Ажиглагч бүртгүүлэх, ажиглагчийн үнэмлэх авахад болон эрхээ эдлэхэд нь холбогдох этгээд аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно.

107.15 Энэ хуулийн 107 дугаар зүйлд заасныг зөрчсөн сонгуулийн байгууллагын ажилтан болон аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.2 Төрийн бус байгууллагын ажиглагчийн эрх, үүрэг

Өмнө дурдсанаар СтХ-д ажиглагчийн эрх, үүргийг тусгайлан зааж өгсөн. Энэ нь хуулиар сонгуулийн өдрийн санал авах ажиллагааны үйл явцыг бүхэлд нь буюу нээлтийн хэсгээс хаалт хүртэл хугацаанд ажиглах эрхтэй байхаар заасан нь давуу тал болсон. Мөн хуулийн 108.1-т “Ажиглагч сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг **зөвхөн хөндлөнгөөс ажиглана**” гэж заасан байна. Мөн 108.2 дугаарт нийт 12 төрлийн эрх эдлэх болохыг тодорхой тусгасан ба эдгээр эрх нь мэдээлэл авах, түгээх, санал гомдол гаргах зэрэг боломжийг бүрдүүлсэн нь “ил тод байх” зарчмыг дэлгэрүүлсэн заалт болсон гэж үзэж болно.

Сонгуулийн тухай хуулиас...

108.2 Ажиглагч дараах эрх эдэлнэ:

108.2.1 сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;

108.2.2 саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах;

108.2.3 санал авах, тоолох ажлыг ажиглах;

108.2.4 зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарь, явцтай танилцах;

108.2.5 санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

108.2.6 санал авах байранд санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх;

108.2.7 санал авах үйл явцад зөрчил гарвал санал авах байрын ахлах зохион байгуулагчид мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, баримтжуулах, гэрчээр гарын үсэг зуруулах;

108.2.8 дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;

108.2.9 санал авах байрын ахлах зохион байгуулагчаас холбогдох мэдээлэл авах,

сонгуулийн байгууллагын үйл ажиллагааг ажиглах;

108.2.10 ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх;

108.2.11 саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах;

108.2 12 хууль тогтоомжид заасан бусад.

108.4 Энэ хуулийн 108 дугаар зүйлд заасныг зөрчсөн сонгуулийн байгууллагын ажилтан болон аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.3 Сонгуулийн санал авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Санал авах ажиллагааг СтХ-ийн 11 дүгээр бүлгээр зохицуулсан. Тус хуулийн 87.1-т “Сонгогчдын саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00 цагаас 22.00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна” гэж заасан. Ийнхүү санал авах ажиллагааг 07:00 цагт эхлүүлэхийн өмнө санал авах байрны бүрэлдэхүүн дараах ажиллагааг доор дурдсан дарааллын дагуу гүйцэтгэж тэмдэглэл үйлдэхийг СтХ-ийн 89 дүгээр зүйлд тодорхой заасан бөгөөд ажиглагчдыг байлцуулахаар заасан байна. Энэхүү ажиллагаа нь дараах алхмаас бүрдэнэ:

- Тухайн санал авах байрны сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын тоог мэдээлэх;
- Санал авах байрны байршлаас хамааран тусгайлан тогтоосон саналын хуудасны индекс, дугаарыг мэдээлэх
- Хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахад зарцуулсан, саналаа буруу тэмдэглэсэн үндэслэлээр дахин олгосон зэрэг, алдагдаж, үрэгдсэн, устгагдсан болон үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх
- Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулан хоосон эсэхийг бататгаад, санал тоолох төхөөрөмжийг битүүмжлэн, лацдаж, санал авахад бэлэн болгох;
- Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын саналыг санал тоолох төхөөрөмжид хийн, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар бүртгэлийн хуудас гаргуулна.

Сонгогч санал өгөхийг СтХ-ийн 92 дугаар зүйлд заасан. Хуульд зааснаар сонгогч үндсэн 3 алхмын дагуу саналаа өгнө:

1-р алхам. Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах ажиллагаа:

Хурууны хээ болон иргэний үнэмлэхийг тулган шалгасны үндсэн дээр бүртгэлийн хуудсыг өгнө. Сонгогчийн бүртгэлийн хуудас болон иргэний үнэмлэхийг тулган шалгаад саналын хуудсыг олгоно. Ийнхүү сонгогч саналын хуудас хүлээн авсан болохоо баталгаажуулж гарын үсэг зурна.

2-р алхам. Санал тэмдэглэх:

Сонгогч санал бэлтгэх бүхээг дэх зааварчилгаатай танилцана. Мөн саналын хуудас дахь товч заавартай танилцаж болох бөгөөд саналын хуудаст мандатын тоотой тэнцүү нэр дэвшигч болон зөвхөн нэг нам, эвслийн төлөө саналаа ДҮҮРГЭН БУДАЖ саналаа тэмдэглэнэ. Сонгогч Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн хурлын сонгуульд тойрогт ногдсон мандатын тооноос илүү нэр дэвшигчийн төлөө өгсөн саналын хуудсыг хүчингүй байхаар зохицуулсан. Харин сонгогч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тооцно.

3-р алхам. Саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийх:

Төхөөрөмжийн дэлгэцэнд “САНАЛЫН ХУУДАС УНШИХАД БЭЛЭН” гэсэн мэдээлэл гарч ирсний дараа аль ч талаар нь харуулан саналын хуудсыг хийнэ. Саналын хуудас хийсний дараа “САНАЛЫН ХУУДАС АМЖИЛТТАЙ УНШИГДЛАА” гэсэн мэдээлэл гарч ирснээр санал тоологдоно.

Сонгуулийн тухай хуулиас...

92.2. Сонгогчоос саналаа өгөхөд дараах зүйлийг хориглоно:

92.2.1 тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;

92.2.2 өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох;

92.2.3 тухайн санал авах байраас олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах;

92.2.4 санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;

92.2.5 саналын хуудаст тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг

баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх; 92.2.6 саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах; 92.2.7 аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.
--

3.4 Сонгуулийн санал тоолох, дүн гаргах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Санал хураалтын дүн гаргах, нэгтгэх үйл ажиллагааг СтХ-иар арван хоёрдугаар бүлэгт зохицуулсан. Хуулийн зохицуулалтаас үзэхэд санал тоолох ажиллагааны бэлтгэл, санал тоолох ажиллагаа, саналын хуудасны тоог нягтлах, санал хураалтын дүн, баримт бичгийг хүргүүлэх гэсэн дараалалтай байхаар зохицуулсан байна. Хуулийн 97.1-т “Хэсэгт санал тоолох ажиллагааг санал авах ажиллагаа дуусмагц эхэлж, **ажиглагч**, хэвлэл мэдээллийн байгууллагын **төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна**” гэж заасан. Санал тоолох ажиллагаа нь дараах алхмаас бүрдэнэ:

Санал тоолох ажиллагааны бэлтгэл:

Санал тоолох ажиллагааг санал авах ажиллагаа 22 цагт дуусмагц эхэлж, дараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Саналаа өгсөн (зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар болон санал авах байранд) сонгогчдын тоо нь сонгогчдод олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, тооцоо гаргах;
- Санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган битүүмжлэх.

Санал тоолох ажиллагаа:

Дээрх ажиллагааг хийсний дараа саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолно. Мөн 22:00 цагаас өмнө санал тоолох төхөөрөмжөөр санал тоолохыг хориглосон. Түүнчлэн санал тоолж эхэлсэнээс хойш санал хураалтын дүн гарч дуусах хүртэл хэсгийн хорооны үйл ажиллагаа завсарлаж болохгүй.

Төхөөрөмж “санал хураалтын дүнгийн хуудас”-ыг хэвлэж гаргана. Санал хураалтын үр дүнгийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хороонд нэн даруй дамжуулах ба санал хураалтын дүнд дараах мэдээлэл багтсан байна.

- Тухайн хэсэгт бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо
- Санал өгсөн нийт сонгогчдын тоо
- Нэр дэвшигч бүрийн авсан хүчинтэй саналын тоо

- Нэр дэвшигч бүрийн авсан хүчингүй саналын тоо.

Санал хураалтын дүнг уншиж сонсгосны дараа, санал тоолох төхөөрөмжөөс хэвлэсэн санал хураалтын дүнгийн хуудсанд санал авах байрны ахлах зохион байгуулагч гарын үсэг зурна.

Хүчинтэй ба хүчингүй санал:

Хүчингүй саналын хуудас болон хүчингүй санал хоёр нь ялгаатай ойлголт бөгөөд саналын хайрцаг /санал тоолох төхөөрөмж/-аас гарч ирсэн саналын хуудас бүхэн хүчинтэй саналын хуудаст тооцогдоно. Харин дараах санал хүчингүйд тооцогдохоор хуульчилсан. Үүнд:

- Саналын хуудас хэвлэгдсэний дараа хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийн бүртгэлээс хасагдсан нэр дэвшигчийн төлөө өгсөн санал;
- Тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүү нэр дэвшигчийн төлөө өгсөн санал.

Дээрх хоёр шалтгаанаар санал хүчингүй байх нь саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

Саналын хуудасны тоог түлгэж нягтлах:

Санал авахад зарцуулсан болон зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн санал авах байр хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл санал авах байр шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолно. Ийнхүү дахин тоолсон ч саналын хуудасны зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, саналын хуудас тоолоход оролцсон хэсгийн хорооны ажилтнууд гарын үсэг зурна.

Санал хураалтын дүн, баримт бичгийг хүргүүлэх:

Санал авах байр дараах баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд хүргэнэ. Үүнд:

(a) Ахлах зохион байгуулагчийн гарын үсэг зурсан санал хураалтын дүнгийн хуудас

(b) Санал тоолох ажиллагааны бэлтгэл шатанд битүүмжилж бэлтгэсэн саналын хуудаснууд

Эдгээр баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд хүргэх бэлтгэл ажил хангагдсанаар ажиглагч хэсгийн хорооны байрыг орхин явах боломжтой болох юм.

Сонгуулийн тухай хуулиас...

103.1 Доор дурдсан зөрчил сонгуулийн дүнд ноцтойгоор нөлөөлөхөөр бол зөрчил гарсан хэсгийн санал хураалтыг хүчингүйд тооцно:

103.1.1 байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан;

103.1.2 хуульд зааснаас өөр өдөр санал авсан;

- 103.1.3 санал авсан зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн;
- 103.1.4 сонгогчид хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, сонгуулийн дүнг гажуудуулахад хүргэсэн;
- 103.1.5 сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих, санал авах ажлыг зохион байгуулах журмыг зөрчсөн.

Техникийн тооллого хийх эрх зүйн зохицуулалт

Санал хураалтын дүнг төв серверт дамжуулсны дараа СтХ-д зааснаар техникийн тооллого явагдаж болно. Техникийн тооллого гэдэг нь санал тоолох төхөөрөмжийн дүн, уншигдсан саналын хуудасны дүнтэй таарч буй эсэхийг гар ажиллагаагаар тоолж, баримтжуулах ажиллагаа юм. Хуулийн 97.13-т “Санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар харьяа хэсгийн хорооноос **50 хүртэл хувийг сонгож 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ**. Техникийн тооллогод сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн болон сонгогчдын төлөөллийг оролцуулна” гэж заасан.

Мөн хуулийн 97.14-т “Техникийн тооллого хийх журмыг сонгуулийн төв байгууллага батална” гэсний дагуу СЕХ-ноос 2016 оны 6-р сарын 21-ний 172 дугаар тогтоолоор “Техникийн тооллого хийх журам”-ыг баталсан. Тус журмын 1.3-т “Техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгох болон техникийн тооллого хийх ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагчид, сонгогчид, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно” гэсэн. Мөн журмын 2.1-д зааснаар техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгохдоо сум, дүүргийн сонгуулийн хороо сугалаа явуулахаар зохицуулсан.

Ийнхүү техникийн тооллого хийх хэсгийн хороод тодорхой болсны дараа тухайн хэсгийн хороод дараах зохион байгуулалтаар техникийн тооллого явуулах бөгөөд ил тод, нээлттэй зохион байгуулна. Үүнд:

1. Эхлэхийн өмнөх бэлтгэл ажил: Санал авах ажиллагаанд зориулсан бүх үзгийг хураан авч битүүмжлэх, саналын хайрцагны лацын бүрэн бүтэн байдлыг шалгуулсны үндсэн дээр хөндөх, саналын хуудсыг тус бүр 25 ширхэгээр нь тоолж багцлан, багц тус бүр болон саналын хуудсыг дугаарлах, саналын хуудасны тоо нь сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ.
2. Тооллого хийх: Багцалсан саналын хуудсыг дугаарласан дарааллын дагуу нэг бүрээр нь уншиж танилцуулах ба ажиглагчдад ил тод харуулна.

3. Дүнг нэгтгэх: Нэр дэвшигчид өгсөн саналыг тоолохдоо саналын хуудас тус бүрээр тоолж, багц тус бүрээр дүнг нэгтгэн гарган дүнгийн нэгтгэлд бүртгэн, дүнг гаргаж мэдээлнэ. Энэ тухайгаа дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдээлнэ.
4. Баримт бичиг цэгцлэх, хүргүүлэх: Тэмдэглэл болон бусад баримт бичгийг дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй хүлээлгэн өгнө.

Техникийн тооллогыг явагдаж дууссанаар саналын дүн гаргах ажиллагаа дуусгавар болно.

ДӨРӨВ. АЖИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Дотоодын байгууллагын ажиглагчийг бэлтгэх үйл явц

Ажиглагчдыг бүрдүүлэхдээ өмнөх 2012 оны ажиглагчдын мэдээлэл дээр үндэслэн мэдээлэл хүргэсэн, түүнчлэн залуучуудын иргэний нийгмийн сүлжээгээр дамжуулан сонгуулийн үйл явцыг ажиглах талаар удаа дараа үүлзалт, хэлэлцүүлэг бүхий чөлөөт арга хэмжээ зохион байгуулах замаар бүрдүүлсэн.

Төслийн багийн зүгээс эрсдэлийг тооцон нийт 230 гаруй ажиглалаар ажиллах хүсэлтэй хүмүүсийг бүртгэж авсан ба эдгээрээс цөөн тооны хүн тодорхой шалтгаануудаар ажиглагч болохоос татгалзаж үүнээс үүдэн богино хугацаанд шинэ ажиглагч нэмж элсүүлэх шаардлага гарч байсан. Дээрх бэрхшээлийг ажиглагчдийг зохион байгуулах, мэдээлэл нэгтгэх, шаардлагатай үед шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй зохицуулагч, дэд зохицуулагч, багийн ахлагчид шуурхай ажиллаж, төлөвлөсөн 202 ажиглагчийг ажилуулсан.

СЕХ-оос 2016 оны 3-р сарын 23-ны өдөр баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам,”-д заасан эрхийн дагуу ажиглагчдыг 2 шаттай сургалтад хамруулсан.

Эхний шатанд ажиглалтыг зохион байгуулж буй удирдан чиглүүлэх багт зориулан сонгуулийн хуулийн агуулга, хэрэгжилтийн явцад тулгардаг бэрхшээл болон автоматжуулсан сонгуулийн зарчим, үйл явц, эрсдэл, давуу болон сөрөг талууд, сонгуулийн өдрийн ажиглалтын шалгах хуудсыг хэрхэн боловсруулах, ажиглалтын тайлан боловсруулж бичих аргачлал, сонгуулийн ажиглагчийн эрх, үүрэг, хариуцлага, дагаж мөрдөх ёс зүйн зарчмын талаар ойлголт өгөх зорилготой 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Энэ сургалтыг төслийг хэрэгжүүлэгчид өмнөх сонгуулийн ажиглалтын туршлага болон ОУ-ын сайн туршлагуудаар баяжуулсан агуулгаар зохион байгуулсан.

2016 оны 4-р сарын 20-ны өдөр. Сонгуулийн ажиглалтын багийн ахлагч нарыг сонгон томилж, төслийн үйл ажиллагааг танилцуулж, ажил үүргийн хуваарийн талаар хэлэлцэж, харилцан ойлголцлын санамж бичигт гар үсэг зурав.

2016 оны 5-р сарын 7, 14, 21, 28-ны өдрүүд. Сайн дурын ажиглагч элсүүлэх 5 удаагийн үүлзалтаар залуучуудад төслийн ерөнхий танилцуулга, Сонгуулийн ажиглалт баримтат нэвтрүүлэг, Сонгуулийн ажиглагч ток шоу, Залуучууд бид юу хийж чадах вэ? зэрэг хөтөлбөртэйгээр зохион байгуулсан.

Сонгуулийн ажиглагчдыг элсүүлэхдээ дараах шалгуурыг мөрдлөг болгосон. Үүнд:

- сонгуульд оролцох 18 насанд хүрсэн;
- Монгол улсын иргэн;
- сонгуульд идэвхтэй оролцох, сонгуулийг ажиглах хүсэлтэй;
- артивист “МИНИЙ ГАР” үйл ажиллагаанд оролцох боломжтой;
- аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, үйлчлэхгүй;
- төвийг сахиж, иргэний нийгмийн, хөндлөнгийн ажиглалтыг сайн дурын үндсэн дээр, хариуцлагатай хийх 18-35 насны иргэний нийгмийн, бие даасан ажиглагчдыг элсүүлэн бүртгэсэн.

2016 оны 6-р сарын 11-ний өдөр. “Супер баатруудын салхилалт” сэдэвт багийн ахлагч, сайн дурын ажилтнууд бие биетэйгээ танилцах, сүлжээ үүсгэх чөлөөт арга хэмжээг зохион байгуулсан.

2016 оны 6-р сарын 18, 19-ний өдрүүд. Томилогдсон ажиглагчдад зориулсан сонгуулийн талаарх суурь мэдлэг, мэдээлэл түгээх, сонгуулийн эрх зүйн орчны талаар тодорхой ойлголт өгөх, аргачлал эзэмшүүлэх оролцоонд суурилсан, өртөөчилсөн хэлбэртэй хагас өдрийн сургалтыг 5 удаа зохион байгуулж нийт ажиглагчдыг бэлтгэсэн.

Сургалтаар ажиглагчид

- ✓ 1-р өртөө дээр шалгах хуудасны бүтэц, хэрхэн бөглөх талаар,
- ✓ 2-р өртөө дээр сонгуулийн тухай хууль, сонгуулийн зарчмын талаар,
- ✓ 3-р өртөө дээр сонгуулийн тухай худал ба үнэн мэдээлэл,
- ✓ 4-р өртөө дээр сонгуулийн өдрийн жүжигчилсэн тоглолт (mock election), тус өртөө дээр шалгах хуудсын дагуу зөрчлийг тэмдэглэх гэсэн тус тус 30 минутын хэлбэрээр явагдсан.

Төслийн удирдах багийн гишүүд, багийн ахлагч нар мөн ажиглагчид нь сонгуулийг ажиглахдаа аливаа нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг төлөөлөхгүй, төвийг сахиж, сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд ажиллах Иргэний нийгмийн ажиглагчийн ёс зүйг дурьдсан харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

4.2 Дотоодын байгууллагын ажиглагчаар бүртгүүлэх үйл явц

Сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах ажиллагааг Төрийн бус байгууллагаас буюу Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд ТББ, Бодлогод залуусын хяналт ТББ нар Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын нийт 9 дүүргийн УИХ-ын

сонгуулийн 100 хэсгийн хороонд 200 ажиглагчийг ажиллуулахаар урьдчилан төлөвлөсөн ба зохих журмын дагуу бүртгүүлж дууссаны дараа Улаанбаатар хотын 9 дүүргийн хэсгийн хорооны 25 хувь буюу 101 хэсгийн хороонд 202 ажиглагчыг ажиллуулав.

Сонгуулийн үйл явцыг төрийн бус байгууллагаас ажиглагч ажиглах эрх зүйн зохицуулалт:

Сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт ТББ болон улс төрийн намаас ажиглагчийг томилон, сонгуулийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үйл явц, ажиглагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульд тусгасан ба СЕХ-оос баталсан “Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам,”-ийн хүрээнд ажиллаа.

Ажиглагчийг бүртгүүлэх:

Нийслэлийн хэмжээнд хэсгийн хороодыг хуулийн хугацаанд багтааж эцэслэн нэгтгээгүй, мэдээллээ нийтэд ил мэдээлэхгүй байсан нь ажиглагчдыг бүртгүүлэх ажлын явцыг удаашруулж байсан ба төслийн багаас дүүрэг тус бүр лүү утасдаж мэдээлэл авахыг хүсэхэд зарим нь өөрийн вэбсайт дээр мэдээлэл тавьсан, зарим нь албан бичиг бичиж мэдээлэл авахыг шаардсан, зарим нь огт хариу мэдэгдээгүй учраас Сонгогчдын боловсрол төвөөр дамжуулан холбогдож, хэсгийн хороодын эцэслэгдсэн мэдээллийг олж авч байсан.

Иймээс богино хугацаанд ажиглагчдыг бүртгүүлэх шаардлагатай болсон. Уг үйл явц бэрхшээл багатай байсан боловч Сонгуулийн тухай хуулийн 107-р зүйлд заагдаагүй бичиг баримт нэхэх, нэмэлт тодорхойлолт шаардах, хоёр ажиглагч ээлжээр сэлгэн суухыг хориглох, танхимын багтаамж бага тул хагас өдрөөр бусад намын ажиглагчидтай ээлжлэх хэрэгтэй зэрэг хуульд заагаагүй шаардлагуудыг тавьж, бидний ажилд хүндрэл учруулж байсан нь сонгуулийн хуулийн холбогдох заалтын зорилгыг зөрчсөн гэж дүгнэж байна.

Сонгуулийн хуулийн 2.1-д заасан заасны дагуу бид 202 ажиглагчийг бүртгүүлэхээр “Тухайн байгууллагыг бүртгэсэн тухай СЕХ-ны шийдвэрийн хуулбар, биеийн байцаалтын хуулбар (иргэний үнэмлэх, албан), ажиглагчийн анкет”-ыг бүрдүүлэн тойргийн хороодод сонгууль болох өдрөөс 5-7 хоногийн өмнө хүргүүлсэн.

ТАВ. АЖИГЛАЛТЫН ДҮН

5.1 А – САНАЛ АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТ

Ажиглалтанд хамрагдсан санал авах байрны дотно болон гадна орчин хуульд заасны дагуу зохион байгуулагдаж, нөхцлийг бүрдүүлсэн эсэх, түүнчлэн автоматжуулсан системийн бэлэн байдал, санал авах ажиллагааны нээлт хуульд заасан журмын дагуу явагдаж буй эсэхийг хянасан ажиглалтын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

- **Орчин**

Ажиглалтын нэгтгэсэн дүнгээс үзэхэд 90-ээс дээш хувь нь санал авах байрыг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэсэн байжээ. Тухайлбал санал авах байрны орчин, бүрэлдэхүүн бүрэн, аюулгүй байдлыг хангасан, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд үзүүлэх дэлгэцийг бэлдсэн, санал тоолох төхөөрөмж бэлэн байдалтай, ил харагдах эвдрэл гэмтэлгүй байсан зэрэг хэсгийн хороодын зохион байгуулалт сайн байсан боловч дараах дутагдлууд ажиглагдсан байна.

ТББ-ын ажиглагчдын 11 хувь нь санал авах байрны дотоод зохион байгуулалт сонгогчдод ойлгомжгүй байна гэжээ. Мөн 85 хувь нь сонгогч саналаа нууцаар гаргах боломжтой байна гэж үзсэн, гэсэн хэдий ч хэд хэдэн хэсгийн хороо санал бэлтгэх бүхээгүүдийг хооронд нь хэт ойр зайтай байрлуулснаас сонгогч саналаа нууцаар бэлтгэх боломж бага, саналын нууцлал алдагдах магадлалтай байсан.

Тэргэнцэртэй иргэдийг зорчих налуу замыг хэсгийн хороодын 72 хувь нь урьдчилан бэлтгээгүй байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа өгөх нөхцлийг бүрдүүлээгүй байна.

Түүнчлэн ТББ-ын ажиглагчдыг санал авах үйл явцыг саадгүй ажиглах боломжтой орчинг 20 хувь нь бий болгоогүй байна. Ялангуяа жижиг талбайтай санал авах байрны хувьд намын болон ТББ-ын ажиглагчдыг нэг эгнээнд суулгах боломжгүй байснаас хэд хэдэн эгнээгээр суудал бэлтгэж ТББ-ын ажиглагчийг арын эгнээнд суулгаснаас сонгуулийн үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй болох эсвэл огт суудал бэлтгээгүйгээс өдөржин зогсох зэргээр ажиглалтын мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй нөхцлүүд үүссэн байна.

- **Автоматжуулсан системийн бэлэн байдал**

2016 оны УИХ-ын сонгуулийн хувьд автоматжуулсан систем нь сонгогчийн нэрийн жагсаалтын цахим мэдээллийн сан, санал тоолох төхөөрөмж гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүнтэй байснаараа онцлог юм. Цахим мэдээллийн сангийн хувьд сонгогчийн хурууны хээг таних төхөөрөмж, зөөврийн компьютер, сонгогчийн мэдээллийг харуулах дэлгэц зэргийг санал авах байранд заавал бэлтгэж тавьсан байх ёстой бөгөөд бүх санал

авах байранд сонгогчийн бүртгэл дэх зургийг үзүүлэх дэлгэцийг байрлуулсан нь ажиглагчдын мэдээллээс харагдаж байна.

Гэхдээ тодорхой аргачлалын дагуу мэдээлэл цуглуулж буй ТББ-ын ажиглагчдын хувьд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй байжээ. Ялангуяа санал авах ажиллагаа нээгээгүй байхад ажиглагчид төхөөрөмжийн талаарх мэдээллийг цуглуулахаар ойртох, мэдээлэл авахаар хандахад нь зарим хэсгийн хороодын ахлагчид “байхгүй, чамд ямар хамаатай юм бэ, байрандаа суу” гэх зэргээр ил тод байдлыг хангаагүй зөрчил гаргажээ. Иймд ажиглагчдын 84 хувь нь төхөөрөмжийн батерей бүрэн цэнэгтэйг, 71 хувь нь төхөөрөмжийг баталгаажуулсан гэрчилгээтэйг, 93 хувь нь төхөөрөмжид ил харагдах эвдрэл гэмтэл байхгүйг, 81 хувь нь сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж бэлтгэсэн байсныг нүдээр харж баталгаажуулж чаджээ.

- **Санал авах ажиллагааг эхлүүлэх**

Ажиглалтанд хамрагдсан хэсгийн хороодын ихэнх хувь нь санал авах ажиллагааг хуульд заасан хугацаа болох өглөөний 07:00 цагт эхлүүлсэн бөгөөд 6 хэсгийн хороо 06:43-06:59 цагт, 20 хэсгийн хороо 07:02-07:37 минутын хороонд санал авах ажиллагааг эхлүүлсэн байна.

Ажиглагчдын тэмдэглэл, тэдэнтэй хийсэн ярилцлагаас үзвэл хэсгийн хороодын дотоод зохион байгуулалт, ахлагчийн түршлагаас хамаарч нээлтийн ажиллагаа харилцан адилгүй болж өнгөрсөн байна. Тухайлбал зарим хэсгийн хороодын ахлагч нар хийж буй ажиллагаагаа тайлбарлаагүй, хуулийн дарааллын дагуу явуулаагүй, хэлж байгаа нь ажиглагчдад сонсогдоогүй, асуулт тавихад хариулахгүй байх зэрэг шалтгааны улмаас ажиглалтын мэдээлэл авахад хүндрэлтэй байжээ.

Иймд ажиглалтын дүнг нэгтгэн үзвэл хэсгийн хороодын 96 хувь нь санал авах бүх хайрцгийг нээж харуулан шалгасан (1 хэсгийн хороо харуулаагүй), 85 хувь зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн сонгогчдын бүртгэлийн хуудсыг хэвлэж бэлтгэсэн (4 хувь нь хариулаагүй), 80 хувь нь хүлээж авсан, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоог зарласан (10 хувь нь хариулаагүй), 27 хувь нь саналын хуудасны индекс дугаарыг зарласан, нэг хэсгийн хороо зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах хуудсыг уншуулаагүй байна.

Мөн эхлэлийн тэг тайлан хуудсыг 97.9 хувь нь хэвлэсэн гэжээ (1 хэсгийн хороо хэвлээгүй, 1 хэсгийн хороо хариулаагүй). Үүнээс 79 хувь нь ажиглагчдад төхөөрөмжийг шалгасан хуудсыг цаасан хэлбэрээр өгчээ. Тэг тайланг авч чадаагүй ажиглагчдын тэмдэглэлийг үзэхэд зөвхөн нэг хувь хувилж түүнийгээ улс төрийн намын ажиглагчид өгсөн эсвэл харуулчаад буцаагаад авсан, хоёр хувь хэвлэсэн учир өгөөгүй, гэрэл зургийг нь авсан, нэг л машины тайланг өгөөд нөгөөг нь өгөөгүй, өгөхгүй байгаа шалтгаанаа хэлээгүй зэрэг

тайлбарууд нийтлэг байна. Мөн тэг тайлантай танилцсан ажиглагчдын 91 хувь нь ямар нэг алдаа байхгүй байсан гэсэн боловч зарим тэг тайлангийн огноо буруу бичигдсэн, баталгаажуулж гарын үсэг зураагүйг алдаанд авч үзсэн байна.

Ийнхүү хэсгийн хороодын 64 хувь санал авах нээлтийн ажиллагааг нэг бүрчлэн баримтжуулж тэмдэглэл хөтөлсөн гэсэн (23.5 хувь нь үгүй, 12.5 хувь нь хариулаагүй) бөгөөд тэмдэглэлд хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүд гарын үсэг зурсан эсэхийг асуусан асуултанд 43.2 хувь нь “тийм,” мөн адил хувь “үгүй,” 13.6 хувь нь хариулаагүй байна. Түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хэсгийн хороодын 44 хувь нь ТББ-ын ажиглагчаар гарын үсэг зуруулжээ. Энэ нь тэмдэглэлд буй мэдээлэл нийтэд зарласан мэдээлэлтэй тохирч буй эсэхийг нягтлах боломжийг хязгаарласан байна.

5.2 Б - САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

- **Санал авах ажиллагаа**

Ажиглалтанд хамрагдсан хэсгийн хороодын санал авах ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан эсэхийг хянасан ажиглалтын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

Санал авах ажиллагааны үед авах байранд аль нэгэн нам эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа хийгдсэн эсэх гэсэн асуултанд нийт ажиглагчдын 5.4 хувь нь “тийм” гэсэн хариултыг өгсөн байна. Тухайн ажиглагчдын тэмдэглэснээр тухайлсан намын ажиглагчид өөрсдийн намын лого, тэмдэг бүхий тэмдэглэлийн дэвтэр болон энгэрийн тэмдэгтэй ажиглалтаа хийх түүнчлэн хэсгийн хорооны гадна иргэдтэй гар барин мэндчилж, санал солилцох тохиолдлууд илэрсэн байна. Мөн сонгогч аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн тэмдэг зүүсэн байх, сурталчилгааны сонин барьж орж ирэх, саналаа өгөөд гарахдаа бусад сонгогчдод хандан аль нэг нам, эвсэлд саналаа өгөхийг уриалсан үг хэлэх зэрэг тохиолдлууд бүртгэгджээ.

Саналаа өгөхөөр ирсэн сонгогчдын хурууны хээг уншуулж саналын хуудсыг олгосон байна. Долоовор хурууны хээ уншихгүй тохиолдолд бусад хурууны хээг уншуулсан бол зарим хэсгийн хороод дээр регистрийн дугаарыг оруулж бүртгэсэн. Хэсгийн хороодын тал хувьд хурууны хээний мэдээлэлд тулгуурлан сонгогчийн бүртгэлийн хуудсыг олгосон ба тал хэсгийн хороод дээр иргэний үнэмлэхийг давхар нягталж шалгасан байна. Ажиглалтанд хамрагдсан хэсгийн хороодын 2 дээр хурууны хээ уншигчид техникийн саатал гарсан бөгөөд тэр даруй засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын 12.9 хувьд нь сонгогч саналаа санал бэлтгэх бүхээгт нууцаар гаргаагүй тохиолдол бүртгэгдсэн. Ийнхүү хариулсан ажиглагчдын тэмдэглэлд

нэгдүгээрт сонгогчид саналын хуудсанд хэрхэн тэмдэглэх талаар мэдээлэл муутай байсны улмаас санал бэлтгэх бүхээгт очоод бусад хүмүүсийн бүхээг рүү шагайх, саналын хуудсаа бусдад харуулах, бусдад зааж өгөх, хэсгийн хорооны гишүүд болон ажиглагчдаас туслалцаа хүсэх зэргээр саналаа нууцаар гаргаагүй нөхцөл байдал зонхилж байна. Хоёрдугаарт сонгогчид зориудаар саналын бүхээгийн ард утсаар ярих, зураг авах болон гэр бүлээрээ ирсэн сонгогчид бүхээгийн ард ярилцах, хамтдаа сууж саналын хуудсанд тэмдэглэх, тэмдэглэсэн саналаа ажиглагч болон хэсгийн хорооны гишүүд руу харуулах тохиолдлууд гарсан байна. Гуравдугаарт хэсгийн хороодын зай талбай хангалтгүйн улмаас бүхээгүүд хоорондоо хэт ойр байрлах, бүхээгийн тоо сонгогчдод хүрэлцэхгүй байх, үүнээс үүдэн сонгогчийн саналыг бусад хүмүүс харах, мөн хөгжлийн бэрхшээлтэй сонгогч санал бэлтгэх бүхээгт орох боломжгүй байх зэрэг тохиолдол тус тус бүртгэгдсэн нь сонгогч саналаа санал бэлтгэх бүхээгт нууцаар саналаа гаргахад саад учруулсан байна.

Хуульд заасны дагуу саналаа биечлэн өгөх боломжгүй иргэн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах явдал нийт хэсгийн хороодын 74.2 хувьд нь ажиглагдсан. Итгэмжлэгдсэн хүнээр ихэвчлэн гэр бүлийн хүмүүс нь байсан боловч ганцаараа ирсэн өндөр настай, бичиг үсэг тайлагдаагүй, харааны бэрхшээлтэй хүмүүс саналаа өгөхөд бэрхшээл учирсан тул хэсгийн хорооны дарга, гишүүн зэрэг итгэмжлэгдсэн хүн байж болохгүй этгээд туслалцаа үзүүлсэн тохиолдлууд гарсан байна.

Ажиглагчдын 51.6 хувь нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулахад хүндрэл гарсан гэж хариулсан ба нийтлэг хүндрэл нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүйн улмаас саналын хуудсыг нугалсан, саналын хуудасны бар кодыг гэмтээсэн, илүү дутуу бөглөсөн, буруу газар руу нь хийх гэж оролдсон зэрэг тохиолдлууд гарсан. Эдгээрээс шалтгаалан заримдаа санал тоолох төхөөрөмж гацаж мэдээлэл технологийн даамал санал тоолох машиныг унтрааж асаах тохиолдол гарсан байна. Мөн санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг уншихгүй байсан тохиолдолд саналын хуудсыг нөгөө талаар нь эсвэл өөр санал тоолох төхөөрөмжид хийхэд унших тохиолдлууд гарсан байна.

Ажиглалт хийсэн хэсгийн хороодын 42.4 хувьд нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид уншуулах үед саналын нууцлал алдагдаж болзошгүй нөхцөл үүссэн гэж хариулжээ. Ингэж хариулсан нийтлэг шалтгаан нь сонгогч саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийх үед сонгогчид бэрхшээл учирсан тохиолдолд мэдээллийн технологийн даамал болон хэсгийн хорооны гишүүд туслалцаа үзүүлэх эсвэл шаардлага гараагүй байхад саналын хуудсыг харж болохуйц зайнд ойртсоноор саналын хуудасны тэмдэглэгээг бүрэн харж байсан байна.

- **Санал авах ажиллагааны зөрчил**

Нийт хэсгийн хороодын 4.3 хувьд нь (уг хэсгийн хороод тус бүр дээр 10-аас доош тооны) сонгогчийн нэр давхар бүртгэгдсэн тохиолдол гарсан байна. Тухайлбал өрхийн бүртгэл дээр тухайн хаяганд оршин суудаггүй хүний нэр байх тохиолдол гарсан байна.

Мөн хэсгийн хороодын 53.2 хувьд (уг хэсгийн хороод тус бүр дээр 10-аас доош тооны) нэрсийн жагсаалтанд бүртгэгдээгүй сонгогч гарч ирсэн байна. Эдгээрийн нийтлэг шалтгаан нь гадаадаас ирээд бүртгэлээ хийлгэж амжаагүй “түр хасалттай” гэсэн бүртгэлтэй байсан, шилжүүлэг бүрэн хийгдээгүй байсан, түүнчлэн цөөнгүй сонгогч хэсгийн хороогоо андуурч ирсэн зэрэг байна.

Хэсгийн хороодын 19.4 хувьд нэрсийн жагсаалтанд сонгогч нэмж бүртгэсэн тохиолдол гарсан байна. Энэ нь “түр хасав” гэсэн бүртгэлтэй хүмүүс хүсэлтээ бичин бүртгэлээ сэргээж сонгогчийн бүртгэлийн хуудас авсанаар саналаа өгсөн тохиолдлууд байна.

Хэсгийн хороодын 45.2 хувьд нь (уг хэсгийн хороод тус бүр дээр 10-аас доош тооны) сонгогч иргэний бүртгэлээс олгосон лавлагаа, жолооны үнэмлэх, гадаад паспортоор санал өгөх гэж ирэх эсвэл бичиг баримтын мэдээлэл нь зөрүүтэй байх, орон нутгаас нийслэлд нүүж ирсэн боловч хаягийн шилжилт хийлгээгүй байх тохиолдлууд бүртгэгджээ.

Санал авах ажиллагааны үед сонгогч хэсгийн хорооны гишүүдэд гомдол гаргасан тохиолдол нийт хэсгийн хороодын 50.5 хувьд нь (уг хэсгийн хороод тус бүр дээр 10-аас доош тооны) ажиглагдсан байна. Иргэд хамгийн ихээр гомдол гаргаж байсан үндэслэл нь тухайн хаяган дээрээ оршин суудаг байхад сонгогчийн нэрийн жагсаалтанд бүртгэгдээгүй байсантай холбоотой байна. Мөн өөрийнх нь хаяг дээр амьдардаггүй хүн бүртгэлтэй байгааг хасуулах гэсэн гомдол, хүсэлт гаргасан, түүнчлэн саналаа өгөх гэж ирсэн сонгогчдын урт дараалал үүссэн байна. Түүнчлэн санал авах байр хэт хол байсан мөн өмнөх сонгуулиудад санал өгч байсан санал авах байр нь өөрчлөгдсөн тул хэсгийн хороогоо андуурч ирэх тохиолдол их байгаад бухимдсан сонгогчид байсан байна.

Нийт хэсгийн хороодын 46.2 хувьд нь сонгогч ямар нэг байдлаар зөрчил гаргасан тохиолдол бүртгэгдсэн. Сонгогчдын түгээмэл гаргасан зөрчил нь саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусдад харуулах, санал бэлтгэх бүхээгний ард утсаар ярих, бусад сонгогчийн санал бэлтгэх бүхээг рүү шагайх, ярилцах зэрэг зөрчил байв. Түүнчлэн санал авах байранд сонгуулийн сурталчилгаа хийх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ танхайрсан зөрчил гаргажээ. Эдгээрээс гадна гадаад улсад байхдаа саналаа өгсөн хүн дахин санал өгөхийг оролдох, саналаа өгсөн сонгогч дахин санал өгөхөөр орж ирэх, хүүхдийнхээ бичиг баримтаар санал өгөхийг оролдох, нэг сонгогч хоёр саналын хуудас авч түүнийгээ хамтад нь төхөөрөмжид

уншуулахаар оролдох, нэг сонгогч гурван хүний саналын хуудсыг төхөөрөмжид уншуулахыг завдах тохиолдол тус тус нэг бүртгэгдсэн байна.

Хэсгийн хороодын 35.5 хувьд нь саналын хуудастай холбоотой зөрчил гарсан гэж ажиглагчид бүртгэсэн байна. Нийтлэг буюу удаа дараа бүртгэгдсэн тохиолдлууд нь саналын хуудсан дээр буруу тэмдэглэгээ хийсэн, мандатын тооноос илүү дугуйлсан, саналын хуудсыг нугалсан зэрэг байна.

Түүнчлэн хэсгийн хороодын 49.5 хувьд нь сонгогчид зөрчил гаргасан тохиолдлууд бүртгэгдсэн байна. Үүнд нийтлэг байдлаар гар утсаараа саналын хуудасны зураг бичлэг авах, саналын бүхээгийн ард утсаар ярих, бусадтай ярилцах, согтуугаар ирж санал өгөх, саналын хуудсаа бусдад харуулах гэж оролдох, саналын хуудсыг хайхрамжгүйгээр буруу бөглөх зэрэг тохиолдлууд гарсан байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдаас хэсгийн хороонд санал, гомдол гаргасан тохиолдол хэсгийн хороодын 58.1 хувьд нь гарсан. Тэдгээрийн санал, гомдол гаргасан үндэслэлийг дурдвал хэсгийн хорооны зохион байгуулалт муу байх, ажиглагчдын суудал ажиглалт хийх боломжгүй байрлалд байх, сонгогчийн мэдээлэл гарах дэлгэц ажиглагчдад харагдахгүй байх, хэсгийн хорооны дарга намуудын ажиглагч нарт ялгавартай хандах, санал тоолох төхөөрөмж гацах, саналын хуудсыг зажлах, мэдээллийн технологийн даамал сонгогчийн саналын хуудсыг харах, хүрэх, нэрийн жагсаалтан дахь сонгогчийн тоо СЕХ-ны вэбсайт дахь тооноос зөрүүтэй байх, санал авах байранд нам, эвсэл, нэр дэвшигчийн ухуулагч байна, сонгогчидтой харилцаж нөлөөлөх гэж оролдож байна гэсэн гомдлууд байсан бөгөөд зохих арга хэмжээ авахыг хүссэн байна. Мөн зарим хэсгийн хороод дээр саналын хуудсын бөглөх заавар өгөхдөө “энд дугуйлна уу” гэж зааж өгч байна, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь биш хэрнээ хэсгийн хорооны гишүүд зарим өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүмүүст саналын хуудсыг бөглөхөд нь туслах гэж оролдсон гэж гомдоллосон.

Санал авах ажиллагааны үеэр гарсан санал гомдлыг хэсгийн хорооны ахлагч нийтлэг тохиолдолд хүлээн аваагүй байна. Ажиглагчдыг санал гомдлыг ойшоохгүй өнгөрөх хандлага илэрч байсан байна. Мөн гомдлыг хүлээн авсан тохиолдолд тухайлсан тохиолдлуудад шийдвэрлэхдээ албан тэмдэглэл хөтлөөгүй байна.

- **Санал тоолох төхөөрөмжийн саатал, гэмтэл**

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороодын 20.4 хувьд нь санал авах ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж, түүний иж бүрдэлд ямар нэгэн байдлаар саатал гацалт, түр зогсолт учирсан. Ихэнх тохиолдолд сонгогчдын санал тоолох төхөөрөмжид саналын

хуудсыг хэрхэн уншуулах тухай ойлголт дутмаг байсан бөгөөд саналын хуудсыг хөндлөнгөөр нь хийх, нэг саналын хуудсыг уншиж дуусаагүй байхад дараагийн хуудсыг уншуулахыг оролдох зэрэг байдлаар саналын хуудсаа төхөөрөмжид буруу хийж төхөөрөмжийг гацааж байсан тухай ажиглагчид мэдээлсэн байна. Түүнчлэн төхөөрөмжийн саналын хуудас татдаг хэсэг буюу толгой бохирдож төхөөрөмж ажиллагаагүй болох, иргэний бүртгэлийн сүлжээ тасалдаж гарын хурууны хээ таних төхөөрөмж ажиллагаагүй болох тохиолдол ажиглагдсан.

Нийт хэсгийн хороодын 2.2 хувьд нь санал авах байрны тог тохиолдлын чанартай 4-10 минутын хугацаагаар тасарсан ба энэ үед зөөврийн компьютер, санал тоолох төхөөрөмж зэрэг нь өөрийн нөөц баттерейгаар ажиллаж хэвийн явагджээ. Мэдээллийн технологийн даамал санал тоолох төхөөрөмж, түүний иж бүрдэлд наад захын засвар үйлчилгээ хийх мэдлэг, чадваргүй байсан нь хэсгийн хорооны үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явуулахад хүндрэл учруулсан тухай зарим ажиглагчид тэмдэглэсэн байна.

Дээрх тохиолдлууд нь санал авах ажиллагааг таслалдуулаагүй, ихэнх тохиолдолд төхөөрөмж хэвийн ажиллагаанд орсон бөгөөд саатал учирсан үед бусад санал тоолох төхөөрөмжийг ашигласан. Эдгээр саатал, гэмтэл учирсан тохиолдлын 39.8 хувьд нь тохиолдол тухай бүрт тэмдэглэл үйлдэгдээгүй гэж ажиглагчид бүртгэсэн байна.

Хэсгийн хороодын санал авах ажиллагаа завсарлагагүй, үргэлжлэн явагдсан байна. Мөн санал авах ажиллагаа нь хуульд заасны дагуу явагдаж ямар нэг хэлбэр, шалтгаанаар гар ажиллагаанд шилжээгүй болно.

5.3 В – САНАЛ ТООЛОХ, САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ГАРГАХ, ТЕХНИКИЙН ТООЛЛОГО

Сонгуулийн өдрийн үйл явц бүхэлдээ хуульд заасны дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих нь ажиглалтын зорилго байсан. Иймд санал хураалтыг дүн гаргах болон техникийн тооллого хийж дүнг баталгаажуулж дуусах хүртэлх хугацаанд ажиглалтын мэдээллийг цуглуулсан. Санал тоолох үйл явцыг төрийн бус байгууллагын 101 ажиглагч хэсгийн хороодод биечлэн ажиллаж, санал тоолох үйл явц бүрээр мэдээллийг нэгтгэлээ.

- **Санал авах ажиллагааны хаалт**

Сонгуулийн өдрийн 22:00 цагт иргэний бүртгэлийн сүлжээ зогсож хурууны хээ таних төхөөрөмж ажиллахгүй болсноор сонгуулийн хэсгийн хороодын санал авах ажиллагаа хуульд заасан хугацаанд дууссан байна.

Хуульд заасны дагуу санал авах ажиллагаа 22:00 цагт дуусах ёстой бөгөөд ажиглалтанд хамрагдсан хэсгийн хороодын 87.5 хувь нь тус цагийг баримталж, үлдсэн хэсгийн хороодод 22:14 цаг гэхэд санал авах үйл явц дуусчээ. Энэхүү ажиллагаа дуусахад хэсгийн

хороодын 71.9 хувьд сонгогчийн бөөгнөрөл үүсээгүй бөгөөд 13 хэсгийн хорооны мэдээллийг нэгтгэхэд 100 орчим хүн саналаа өгч чадаагүй байна.

Ажиглагчдын мэдээлснээр нийт хэсгийн хороодын 71.9 хувийн санал авах ажиллагаа хаах үед сонгуулийн санал авах байрны гадна болон дотор саналаа өгч амжилгүй үлдсэн сонгогч байгаагүй. Харин 25.1 хувьд нь 1-50 сонгогч саналаа өгч чадаагүй гадаа үлдсэн гэсэн байна.

- **Санал тоолох ажиллагааны бэлтгэл**

Санал авах ажиллагаа дуусмагц хуульд заасны дагуу санал тоолох үйл явц шууд үргэлжлэх ёстой бөгөөд хэсгийн хороод урьдчилан зохион байгуулалтанд орж, тодорхой бэлтгэлийг хангасан байх шаардлагатай. Ажиглагчдын мэдээллээс үзэхэд 86.5 хувьд нь санал тоолох ажиллагааны талаарх хэсгийн хорооны ажлын зохион байгуулалт тодорхой байж, 70.8 хувь ажил үүргийн хуваарийг урьдчилан баталсан, 69.8 хувьд нь тэмдэглэл хөтлөх үүргийг тусгайлан хүлээсэн гишүүн ажиллажээ. Энэ нь хэсгийн хороодын зохион байгуулалтыг жигдрүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Мөн ажиглагчдын 86 хувьд санал тоолох үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаж болохуйц нөхцлийг бүрдүүлсэн байна. Зарим хэсгийн хороодод зай талбай хангалтгүй, хэт олон ажиглагч байснаас харагдах байдал хязгаарлагджээ.

- **Санал тоолох ажиллагаа**

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын 86.5 хувьд санал тоолох ажиллагаа завсарлалгүй, шууд явагдсан бөгөөд санал тоолох ажиллагаанд ноцтой нөлөөлөхүйц зөрчил, дутагдал ажиглагдаагүй байна. Энэ ажиллагаа нь ерөнхийдөө хуульд заасан журмын дагуу хэвийн явагдсан боловч дараах асуудлуудад анхаарах шаардлагатай нь ажиглалтын дүнгээс харагдаж байна.

Санал тоолох ажиллагаанд зарцуулагдаагүй болон буруу тэмдэглэснээс болж хураагдсан саналын хуудсыг тоолж, хүчингүй болгон битүүмжлэх ажиллагаа ажиглагчдад ил тод, зайлшгүй хийгдэх шаардлагатай боловч хэсгийн хороодын 30 хувь зарцуулаагүй, 11 хувь нь хураагдсан саналын хуудасны баруун дээд өнцгийг хайчлан хүчингүй болгосноо ажиглагчдад харагдахуйцаар зохион байгуулаагүй гэжээ. Мөн зарим хэсгийн хороод битүүмжлэлтэй ашиглагдаагүй саналын хуудсыг тоолж, хүчингүй болгох шаардлагагүй гэж тайлбарлаж, эдгээр хуудсыг хүчингүй болгоогүй байна.

Мөн сонгогчийн нэрсийн жагсаалтанд “түр хасав” төлөвтэй хүмүүсийг сэргээж санал өгүүлсэн тохиолдолд тус тайланг гаргаж, мэдээлэх үүрэгтэй бөгөөд бөгөөд хэсгийн хороодын 72.9 хувь нь л ажиглагчдад дүнг танилцуулсан байна.

- **Санал хураалтын дүн гаргах**

Энэ удаагийн сонгуулиар санал хураалтын дүнг төв серверт дамжуулж, нэгтгэгдэж буй дүн телевизээр шууд цацагдснаараа онцлог байсан. Иймд нийт хэсгийн хороодын 97.9 хувь нь төхөөрөмж тус бүрийн дүнгийн тайланг хэвлэж, 92 хувь нь саналын хуудасны дүнг ажиглагчдад хэвлэж өгсөн ба 73 хувь нь дүнг уншиж сонгон, 93.8 хувь нь тусгай модемоор нэн даруй мэдээлжээ. Харин дүнг дамжуулахад 30-60 минут зарцуулсан 4 хэсгийн хороо байсан байна.

Хэдийгээр төхөөрөмжинд тоологдсон саналын дүнг нийтэд шууд цацагдсан боловч санал тоолох ажиллагааны үйл явц хэсгийн хороод дээр үргэлжлэх ёстой бөгөөд тодорхой алхмуудаар дүнг баталгаажуулахаар хуульд заасан байдаг. Гэтэл энэ үйл явцыг баримтжуулсан тэмдэглэлд хэсгийн хороодын 11 хувь оролцогчдоор гарын үсэг зуруулсан, 19 хувь нь саналын хуудасны зурган файлыг иргэний бүртгэлийн компьютерт хуулж өгч буйгаа ажиглагчдад тодорхой харуулаагүй байна. Мөн 82 хувь нь саналын хуудасны зурган файлыг ажиглагчдад CD дээр хуулж өгсөн бөгөөд үлдсэн хэсгийн хороод техникийн мэдлэг болон бэлтгэл хангалтгүй, зурган файлыг хуулж авах хүсэлтээ бичгээр гаргах, заавал DVD авчрахыг шаардсанаас зарим хэсгийн хорооны мэдээллийг авч чадаагүй.

Мөн 71.9 хувь нь хэвлэгдсэн тайлангийн үзүүлэлтийг санал өгсөн сонгогчдын тоо, зарцуулсан саналын хуудасны тоотой харьцуулж нэгтгэсэн дүнг гаргахад 17.7 хувьд нь саналын хуудасны зөрүү гарсан боловч эдгээр хэсгийн хороо саналын хуудасны зөрүүг бүрэн гаргасан гэж тэмдэглэжээ. Үлдсэн хэсгийн хороодод үйл явцыг хэрхэн зохион байгуулсан нь тодорхойгүй байна.

- **Санал тоолох ажиллагааны зөрчил**

Ажиглалт хийсэн хэсгийн хороодод санал тоолох ажиллагааны үед сонгуулийн үр дүнд нөлөөлөх ноцтой зөрчил, саатал, будлиантуулах оролдлого ажиглагдаагүй байна. Гэсэн хэдий ч зарим хэсгийн хороодод санал тоолох ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй байснаас зохих дарааллын дагуу явагдаагүй зөрчлүүд гарсан байна.

Тухайлбал 11 хэсгийн хороонд санал тоолох үйл явц завсарласан бөгөөд үүний шалтгаан нь санал тоолж хэвлэх үед цаас нь дууссан, зааварчилгаа хүлээсэн, СЕХ-оос техникийн тооллого явагдах эсэхийг хүлээсэн, санал тоолох үйл явцад намын төлөөлөл нэмж орж ирсэн зэрэг шалтгаанаар дүнг гаргахгүй, мэдээллийг дамжуулахгүй хугацаа алдах тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Мөн 1-4 хэсгийн хороодод төхөөрөмжийн түлхүүр мэдээллийн технологийн даамлаас өөр хүнд хадгалагдсан, төхөөрөмжийн үйлдлийн нууц үгийг хэсгийн хорооны даргаас өөр хүн мэдэж байсан, санамж дахь өгөгдлийг тэглэх нууц үгийг хэсгийн хорооны нарийн бичгийн даргаас өөр хүн мэдэж байсан зэрэг зөрчлүүд ажиглагдсан нь цаашид төхөөрөмжийн нууцлалыг хангахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

- **Санал тоолох үе дэх төхөөрөмжийн саатал, гэмтэл**

Санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмжид саатал гарсан тохиолдол 7 хэсгийн хороон дээр гарчээ. Саналын дүн хэвлэх явцад цаас нь гацсан, карт ажиллаагүй, машины толгойг уншуулсан, цаас дууссан гэсэн шалтгаантай байсан нь ажиглагчдын тэмдэглэлд туссан байна. Мөн 8 хэсгийн хорооны санал хураалтын дүнгийн тайлангийн цаг хугацаа нь хэвлэсэн цагтай зөрсөн тохиолдол гарчээ.

- **Техникийн тооллого:**

Төрийн бүс байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл 8 дүүргийн техникийн тооллого явагдах хэсгийн хороодыг сугалах ажиллагаанд хөндлөнгийн ажиглалт хийж оролцсон. Ийнхүү бидний сонгосон 101 хэсгийн хорооноос 23 хэсгийн хороо сугалаагаар сонгогдож, ажиглалтыг үргэлжлүүлсэн.

Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц 100 хувь ажиглагчдад нээлттэй явагдсан ба СЕХ-оос баталсан журмын дагуу явагджээ. Техник тооллого дунджаар 1:30 минутын дараа эхэлсэн ба дунджаар 4-8 цаг үргэлжилжээ. Мөн тэмдэглэлээс үзэхэд техникийн тооллого хийх хэсгийн хороодын 18 нь шууд тооллогыг эхлүүлсэн бол 5 нь завсарлаж байгаад эхэлсэн байна. Лацыг хөндөж байгаа эсэхээ харуулж, саналын хуудас нэг бүрээр уншиж танилцуулсан 18 хэсгийн хороо байна. Журамд заасны дагуу 50 ширхэг хуудсыг нэг багц болгож, багц бүрээр нь дүнг гаргасан 16 хэсгийн хороо байгаа бөгөөд техникийн тооллого хийсэн тэмдэглэлд гарын үсэг зурсан 10 ажиглагч байна.

Мөн энэ хэсгийн хороодын 7 дээр нь саналын хуудас болон санал авах машины санал зөрөх тохиолдол гарсан байна. Тодруулбал 1-10 саналын зөрүү гарах тохиолдлууд байсан ба шалтгаан нь нэр дэвшигчийн өмнөх дугуйг хэтрүүлэн тэмдэглэсэн байдал, мөн хэсгийн хороодын ажилчид олон цаг ажилласны улмаас алдаж тоолох тохиолдлууд ажиглагдсан байна

Ажиглагчдын тэмдэглэл, тэдэнтэй хийсэн ярилцлагаас үзэхэд зарим хэсгийн хороо техникийн тооллого хэрхэн хийх талаар мэдлэг хангалтгүй байснаас юу болж байгаа нь ойлгомжгүй үймэлдэх, завсарлага авч тоолж эхлэхгүй удааширсан, тооллогод ажиглагчийг оролцуулсан ба сонгуулийн дүн гарсан гээд намуудын ажиглагч нар техникийн тооллогын үйл явцыг ажиглахгүй, орхиж явсан зэрэг тохиолдлууд нийтлэг гарчээ.

Энэ нь СЕХ-оос Техникийн тооллого хийх журмыг сонгууль болохоос хэдхэн хоногийн өмнө баталсантай холбоотой байж болох бөгөөд журам батлагдтал техникийн тооллогыг хэрхэн зохион байгуулах гэж буй талаарх мэдээлэл хангалтгүй, тодорхойгүй байсан нь бидэнд ажиглалтын арга зүйг боловсруулахад хүндрэл учруулж байсан юм.

5.4 Ажиглалт хийх үед тулгарсан хүндрэл, бэршээл

2016 оны сонгуулиар анх удаагаа ТББ-ын ажиглагч сонгуулийн явцыг ажиглах боломжийг СтХ-иар тодорхойлж, эрх-үүрэг-хариуцлага болон бүртгэлтэй холбоотой асуудлыг нарийвчлан заасан учир ажиглалт хийхэд ноцтой хүндрэл, бэрхшээл тулгараагүй болно. Ийнхүү хуульд заасны дагуу “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт” сүлжээнээс 101 санал авах байранд хэрэгжүүлсэн энэхүү ажиглалтын үйл ажиллагаанд бэлтгэгдсэн ажиглагчид өглөөний 07:00 цагаас өмнө тус тусын хэсгийн хороодод очиж ажиглалтаа эхлүүлж, санал хураалтын дүн гарч, техникийн тооллогын үйл явцыг бүхэлд нь ажиглаж чадсан.

Тус сүлжээний гишүүн байгууллагууд СЕХ-оос баталсан журмын дагуу байгууллагын дүрэм, гэрчилгээ зэрэг холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, ажиглалтын үйл ажиллагаа хийхээр бүртгүүлж, СЕХ-ны тогтоолоор баталгаажсан юм. Гэсэн хэдий ч СБД-ийн хоёр санал авах байрны ахлах зохион байгуулагчийн зүгээс нэмэлт баримт бичиг жишээлбэл байгууллагын дүрмийг шаардсан бол ЧД-ийн хэсгийн хороод анкетийг заавал компьютерээр шивж, хоёр хувь цээж зураг авчир, харин ХУД-ийн зүгээс нэг л ажиглагчийг бүтэн өдөр ажиллуул гэсэн харилцан адилгүй шаардлагыг тавьж байлаа.

Ажиглалтын үйл ажиллагаа нь багаар бодоход 06:00-23:00 цаг буюу 17 цагийн турш үргэлжлэх бөгөөд хэрэв техникийн тооллого явагдвал 24 цагийн турш ажиллаж болзошгүй байдаг. Гэтэл сайн дурын үндсэн дээр, цалин урамшуулалгүй ажиллаж буй иргэдийг ийнхүү ажиллуулах нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй юм. Иймд ажиглалтыг сүлжээний гишүүн хоёр ТББ хамтран зохион байгуулж, СтХ-ийн 197.2-т **“...төрийн бус байгууллага нь нэг хэсэгт нэг ажиглагч томилон ажиллуулах эрхтэй”** гэж заасныг үндэслэн, хүний эрхийг хангах үүднээс 6-15 цаг, 15 цагаас сонгууль дуустал шаардлагатай тохиолдолд техникийн тооллого дуустал ажиллахаар ажиглагч нарыг байгууллага тус бүрээс томилон ажиллуулсан. Энэ онцлогийг харгалзаагүйгээс хэд хэдэн хэсгийн хороодод санал хураалт эхлэхээс, дуусах хүртэл үйл явцад нэг ажиглагч ажиллаж, ийнхүү ажилласан нэг ажиглагч техникийн тооллогыг дуусгасан тохиолдол гарсан юм. Иймд хуулийн энэхүү заалт нь ТББ-ын онцлогийг харгалзаагүй, иргэдийн сайн дурын оролцоог зарим талаар хязгаарласан үр дагавартай байна.

Мөн санал авах ажиллагааны бүхий л явц (нээлт, санал хураалт, тоолох)-ын үеийн баримтжуулалт болох тэмдэглэл хөтлөлттэй танилцах, төхөөрөмжийн бэлэн байдлыг ажиглах зэргээр холбогдох мэдээллийг цуглуулах боломжийг хэсгийн хороодын зүгээс бүрэн хангаагүй, саадгүй ажиглах боломжийг бүх хэсгийн хороодод бүрдүүлээгүй нь ажиглалтын үйл явцад бэрхшээл үүсгэсэн болохыг нэгтгэсэн дүнг танилцуулсан хэсэгт тодорхой тусгасан байгаа.

Түүнчлэн санал хураалтын дүнг баталгаажуулах техникийн тооллого хийх журмыг СЕХ-оос сонгууль болохоос 3 хоногийн өмнө вэбсайтандаа байрлуулсан бөгөөд 7 хоногийн өмнө журмын төслийг байршуулж, санал авах үйл явцыг эхлүүлсэн. Энэ нь бидэнд техникийн

тооллогын үйл явцыг ажиглаж, баримтжуулах арга зүйг боловсруулахад хүндрэл учруулсан. Түүнчлэн СтХ болон тус журмаар дүүргийн хэсгийн хороодын хэдэн хувьд техникийн тооллого хийх шаардлагатайг тодорхой заагаагүй учир Дүүргийн сонгуулийн хороод өөрсдийн үзэмжээр шийдсэн бөгөөд жишээ нь СБД-ийн хувьд нийт хэсгийн хороодын 49 хувь хүртэл хувьд техникийн тооллого хийсэн бол хамгийн олон хэсгийн хороотой СХД 5 хувь, БЗД 30 хувь, БГД 10 хувь нь зэрэг харилцан адилгүй хувиар техникийн тооллого хийсэн. Ийнхүү шийдвэр гаргасан үйл явц, үндэслэл ТББ-уудад нээлттэй, ил тод болж өнгөрөөгүйг цохон тэмдэглэж байна.

Техникийн тооллого хийх хэсгийн хороодыг сонгохдоо санамсаргүй хэлбэрээр сонгох үйл явцыг Дүүргийн сонгуулийн хороод сугалаа хэлбэрээр зохион байгуулахаар болсон боловч хаана, хэзээ, хэдэн цагт зохион байгуулах гэж буйгаа албан ёсоор зарлаагүй юм. Иймд бид дүүрэг тус бүрт оролцох албан хүсэлтээ бичгээр гаргасан бөгөөд дүүргүүдээс СБД бичгээр хариу ирүүлсэн. СБД-ийн хувьд хууль болон журамд ТББ-ыг оролцуулна гэж заагаагүй байгаа учраас хүлээж авахаас татгалзаж байна гэсэн үндэслэлгүй хариуг ирүүлсэн нь журамд “сонгогчийн төлөөлөл” байж болно гэсэн бүрхэг заалтыг үндэслэл болгосон байсан. Гэтэл СтХ-иар сонгуулийн үйл явц бүхэлдээ ил тод байх зарчмыг зааж, мөн ТББ хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, нээлттэй байхыг зарчмын хэмжээнд тусгаж өгсөн байдаг. Иймд СтХ-ийг үндэслэн бид дахин албан бичгээр хандаж үйл явцыг баримтжуулсан бөгөөд СБД зөвшөөрсөн хариу өгсөн.

Бусад дүүргүүдтэй утсаар холбогдож мэдээлэл авах гэсэн боловч тодорхой хариу хэлэхгүй, сонгуулийн ирцийг хүлээж байна гэх зэргээр дахин дахин холбогдоход хүргэж байсан ба мэдээлэл сонгуулийн өдрийн 19 цагийн орчимд тодорхой болж эхэлсэн. Дүүргийн хэсгийн хороодод сугалах үйл явц дунджаар 21 цагт эхэлсэн боловч зарим дүүрэг хэдэн техникийн тооллого хийх “хэсгийн хороодын хувь” дээр тохиролцож чадахгүй байна гэсэн үндэслэлээр хүлээлгэх, удаашрах тохиолдол гарсан. Мөн ХУД-ийн хувьд энэ үйл явцыг ажиглахад ТББ-аас томилсон хүнийг биш, заавал ажиглагчийн үнэмлэхтэй хүнийг оролцуул гэсэн шаардлагыг хугацаа тулсан хойно тавьсан нь хүндрэл учруулсан.

Дээрх бүх баримтаас үзэхэд хэсгийн хороодоос гадна, дүүргийн сонгуулийн хороод хуулийн хэрэгжилтийг харилцан адилгүй хангаж байгааг харж болно.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний ажиглагчдын 101 хэсгийн хороонд ажиглалт явуулсан мэдээллийг үндэслэн тус хэсгийн хороодын хүрээнд 2016 оны УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүнг гаргах ажиллагаа хуулийн дагуу явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсгийн хороод дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явцад гарсан зарим зөрчил, алдааг дурдвал:

Сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой дүгнэлт

Сонгуулийн хэсгийн хороодын мэдээлэл, байршил зэргийг цаг түлгэж мэдээлсэн нь хэсгийн хороодын болон ажиглалтын зохион байгуулалтын ажилд хүндрэл учруулсан, түүнчлэн ажиглалт хийх дотоодын байгууллага болон түүний ажиглагчдыг бүртгэх журмыг тойргийн хороо, хэсгийн хороод нэг мөр ойлгож хэрэглээгүй байна. Мөн хуульд заасан журмын дагуу санал авах ажиллагааг явуулах үед сонгогчийн саналын нууцлал алдагдаж болохуйц нөхцөл байдал үүсч байсан нь сонгуулийн үндсэн зарчмын нэг болох сонгогч саналаа нууцаар гаргах зарчим алдагдуулсан байна. Техникийн тооллого явуулах болон хэсгийн хороог сонгох журмууд нь тодорхойгүйн улмаас дүүргийн болон хэсгийн хороодод тодорхойгүй байдал үүссэн.

Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт

Сонгуулийн хэсгийн хороодын үйл ажиллагаатай холбоотой дүгнэлтэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саналаа өгөх нөхцөл байдал хангагдаагүй, хэсгийн хорооны зохион байгуулалт улмаас болон санал авах ажиллагааны явцад сонгогчийн саналын хуудсан дах саналын нууцлал алдагдахуйц нөхцөл байдал үүссэн, мөн зарим мэдээллийг ажиглагчдад зарлаагүй бөгөөд бичиг баримттай танилцах боломжоор хангаагүй, журамд заасан ажиллагааг ажиглагчдын ажиглалтаас гадуур хийх, дотоодын байгууллагын ажиглагчдад ялгавартай хандаж ажиглалт хийх нөхцөл боломжоор бүрэн хангахгүй байх, санал тоолох ажиллагаа явуулах дараалал, хийгдвэл зохих ажиллагааны талаар хэсгийн хорооны дарга, гишүүд зохих мэдлэггүй байх, түүний улмаас зарим ажиллагааг орхигдуулах, ажиглагчдыг мэдээлэлтэй танилцах боломжоор хангахгүй байх, санал тоолох ажиллагааны үед утсаар ярих зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Сонгогчдын боловсролтой холбоотой дүгнэлт

Ажиглагчдын мэдээллээс үзвэл сонгогчид саналын хуудсан хэрхэн тэмдэглэгээ хийх, саналын хуудсаа төхөөрөмжид хэрхэн уншуулах талаар хангалттай мэдээлэлгүй байсан байна. Мөн өөрийнхөө нэрийг нэрийн жагсаалтад байгаа эсэхийг нягтлаагүй, хуульд заасан бичиг баримттайгаар санал авах байранд ирэхгүй байсан нь сонгогч өөртөө хүндрэл учруулахад хүрч байсан. Түүнчлэн саналын хуудасныхаа тэмдэглэгээг бусдад харуулах, саналын хуудасны зураг авах, бусад иргэний саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах зэрэг хуульд заасан зөрчлүүдийг гаргасан байна.

Сонгуулийн автоматжуулах иж бүрдэлтэй холбоотой дүгнэлт

Сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагаа нь тогтвортой байсан бөгөөд зарим тохиолдолд иргэний бүртгэлийн сүлжээ тасалдах, санал тоолох төхөөрөмж гацах, саналын хуудсыг уншихгүй байх, төхөөрөмжийн толгой бохирдох, толгой компьютер гацах, дүнг серверт дамжуулах үед сүлжээний ачаалал ихэссэний улмаас гацах, мэдээллийн технологийн даамлын чадвар дутмаг

Сонгуулийн саналыг тоолох дүн гаргахтай холбоотой дүгнэлт

Энэ удаагийн сонгуулиар санал хураалтын дүнг төв серверт дамжуулж, нэгтгэгдэж буй дүн телевизээр шууд цацагдснаараа онцлогтой бөгөөд иргэд сонгогчдод сонгуулийн дүн нээлттэй, шуурхай хүрч байсан.

Зөвлөмж

Ажиглалтын үр дүнгээс үүдэн Сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгуулийн үйл явцыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой зөвлөмж

- Техникийн тооллого явуулах, сугалах зэрэг холбоотой журмыг боловсронгуй, тодорхой болгох, түүнчлэн хэсгийн хороод болон ажиглагчид эдгээр журамтай танилцан хэрэгжүүлэх боломжтой хугацаанд боловсруулан түгээх;
- Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хяналт хийх ТББ-уудын онцлогийг харгалзан, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нэг хэсгийн хороонд ажиллах ажиглагчийн тоог хязгаарлахгүй байхаар тогтоох;
- Сонгогч өөрийн итгэмжлэгдсэн хүний туслалцаа авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Сонгуультай холбоотой хууль, журмуудыг сонгуулийн дүүргийн болон хэсгийн хороод түүнчлэн ажиглалт, мониторинг хэрэгжүүлэх дотоод, гадаадын ажиглагчид

танилцан, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, бодит хангалттай хугацааг тооцон боловсруулан, түгээх;

Сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж

- Дүүргийн болон Хэсгийн хороодын гишүүдийг хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтийн талаарх нэгдсэн ойлголттой болгох сургалтын чанарыг сайжруулах, мэдээллээр бүрэн хангах дээр анхааран ажиллах;
- Дотоодын байгууллагын ажиглагчдын статус, тэдгээрийн эрх үүргийн талаар дүүргийн болон хэсгийн хорооны гишүүдэд таниулах, ийнхүү ажиглагчдад хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд бичиг баримттай танилцах, мэдээлэл авах бодит боломжоор хангахад анхаарах;
- Хэсгийн хороонд сонгуулийн санал авах, санал тоолох, санал хураалтын дүн гаргах бүхий л ажиллагааны үед холбогдох ажиллагаа болон бичиг баримтыг ажиглагчдын нүдэн дээр хийх, холбогдох баримтанд ажиглагчдыг танилцуулж гарын үсэг зуруулах боломж, оролцоогоор хангах;
- Хэсгийн хорооны дарга, гишүүд, мэдээллийн технологийн даамал нь сонгогчид ямар нэгэн байдлаар нөлөөлөх, саналын хуудастай танилцах, сонгогчийн өмнөөс саналын хуудсанд тэмдэглэгээ хийх явдлыг таслан зогсоох;
- Мэдээллийн технологийн даамлын чиг үүргийг өргөжүүлж, холбогдох сургалтыг явуулсаны үндсэн дээр санал тоолох төхөөрөмжөөс бусад тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцдаг болгох;

Сонгогчдын боловсролтой холбоотой зөвлөмж

- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, тухайлбал, саналын хуудсанд хэрхэн тэмдэглэгээ хийх, санал тоолох төхөөрөмжид хэрхэн саналын хуудсаа уншуулах болон сонгогчдод шаардлагатай мэдээллийг нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр цаг алдалгүй хүргэх дээр анхааран ажиллах;
- Сонгогчдод санал авах ажиллагааны үед хориглосон зөрчлийн талаарх мэдлэг ойлголтыг олгох, зөрчсөн тохиолдолд таслан зогсоох арга хэмжээ авах;

Сонгуулийн санал авах байр болон автоматжуулах иж бүрдэлтэй холбоотой зөвлөмж

- Санал авах байрыг бэлтгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэн саналаа хүндрэлгүй өгөх нөхцөл бололцоог хангасан налуу шат, санал бэлтгэх бүхээг, томруулдаг шил зэргийг нийт хэсгийн хороод бүрэн бэлтгэсэн байхад анхаарах; Харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулсан баррел үсэгтэй саналын хуудас хүртээмжтэй бэлтгэх; Мөн санал авах байрыг тухайн барилгын 2, 3, 4 давхарт байгуулахаас зайлсхийх;

- Иргэний бүртгэлийн сүлжээ, санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийн хэвийн ажиллагааг хангах, дүнг төв серверт дамжуулах үед сүлжээний ачааллыг тохируулах арга хэмжээ авдаг байх;